МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,162.124... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.09.06. Лхагва. №150 (4764) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +22
Шөнө +7

УЛС ТӨР

Г.БАТБААТАР: АНАГААХЫН СУРГУУЛЬ АНХДАГЧ БОЛЖ ИХ СУРГУУЛИЙН ХОТХОНЫГ ХОТООС ГАДНА БАРИНА

II-III нүүрт

ДЭЛХИЙ

ХОЙД СОЛОНГОСЫН АСУУДЛААР ЯПОН МОНГОЛТОЙ ТОХИРОЛЦОХ УУ

VI нүүрт

Дугаарын 60 мөр

## Нэг хашаанд нэг л яндан байлгая

О.УЯНГА

Хөхүүрийн ам цаашилж, хүйтний ам наашилж, гадаа сэрүү орж эхэллээ. Есдүгээр сардаа налгархан, дулаан байвал их юм. Аравдугаар сар гарав уу үгүй юу л хүйтрээд эхэлнэ. Хүйтний улирал золгохтой зэрэгцээд Улаанбаатар хот маань утаанбаатар төрхөндөө орно доо. Утааны улирал эхлээд төр засгийн удирдлагууд уран цэцэн үгээрээ уралдаж, шинэ шинэлэг санаагаараа уралдах нь дамжиггүй. Зарим нь бүр “утаагүй” зуухыг солих талаар ч яриад эхэлсэн байна билээ. Гэхдээ эрхэм дарга нар ямар ч санаа гаргаж, хэчнээн ч мөнгө үрлээ гээд Улаанбаатарын утаа нэмэгдсэн үү гэхээс багасаагүй. Зарим албан тушаалтан хагартлаа баяжиж, иргэд нэг зуухыг нөгөөгөөр солиод л өнгөрч байх шиг байна.

Үргэлжлэл нь III нүүрт

АЙЛЧЛАЛ

# ОХУ-ААР ДАМЖИН ТАВАНТОЛГОЙН НҮҮРС ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРНА ГЭВ



Б.ТОГТОХ

Төрийн тэргүүний үүрэгт ажлаа хүлээн авснаас хойш анхны албан ёсны айлчлалаа хойд хөршөөс эхлүүлж буй Х.Баттулга Ерөнхийлөгчийн айлчлал олон улсын анхаарлын төвд буй. Монгол, Хятад, ОХУ гэсэн мөнхийн хөршийн харилцаа шинэ шатанд гарч, гурван улсыг холбосон “Эдийн засгийн коридор” байгуулах асуудал ажил хэрэг болж эхэлсэн энэ үед Ерөнхийлөгчийн айлчлал олон улсынанхааралдбайхньзүйнхэрэг юм. Ерөнхийлөгч энэ удаагийн албан ёсны айлчлалаар Дорнын эдийн засгийн гуравдугаар чуулга уулзалтад оролцохоос гадна ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин, Япон улсын Ерөнхий сайд Шинзо Абэ нартай уулзаж, хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцох юм.

Үргэлжлэл нь II нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

## МАЛЧИН, ТАРИАЛАНЧ ХОЁР ЗОДОЛДОЖ Л БАЙГ УУ

Б.ӨНӨРТОГТОХ

Төв аймгийн Жаргалан суманд амьдардаг танил маань хэдэн малаа хямдхан зарахаар сэтгэл шулуудсанаа ярив. Жилийн дөрвөн улиралд сүү, цагаан идээгээр тасалж үзээгүй саалийн хэдэн үнээгээ хэдхэн төгрөгөөр хямдхан худалдахад хүрсэн шалтгаан нь бэлчээрийн асуудал. Тус сумын нутагт ихэвчлэн газар тариалан эрхэлсэн иргэд амьдардаг учраас хэдэн малаа бэлчээрлүүлэх талбай ч олдохоо больж аргагүйн эрхэнд ийм шийдвэрт хүрчээ. Өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй Газар тариалангийн тухай хуульд газар тариалангийн талбайгаас 500 орчим метр зайнд мал орж ирвэл тухайн мал тариаланчийн эзэмшилд орно гэсэн утга бүхий заалт байдаг. Хатуухан хэлбэл, буудаж хөнөөсөн ч тэдний дурын хэрэг гэсэн үг. Мэдээж монгол хүн буянт малаа буудаж нүгэл үйлдэхгүй ч эзэмшил газарт нь орж ирсэн малыг барьж хашдаг, зодож гэмтээдэг, малчнаас их хэмжээний мөнгө нэхдэг гэх мэт малчин, тариаланч хоёрын дундах зөрчил жилээс жилд улам бүр л эрчээ авч байна. Бэлчээрийн даац хэрээс хэтэрч цөлжилт ихэссэн энэ цагт бэлчээрийн төлөөх дайн малчдын дунд ч өрнөх болсон нь яах аргагүй анхаарал татах сэдэв болчихоод байгаа юм. Нэг хүнд ногдох газар нутгийн хэмжээгээр дэлхийд тэргүүлдэг, асар өргөн уудам газар нутагтай атлаа ам дөрвөлжин газраа булаалдаж хэмээн цэцэрхэх хүмүүс бишгүй л олон гарах биз. Гэвч цөлжилт эрчимтэй явагдаж, малын тоо толгой хүн амын тооноосоо хэдэн зуун саяар илүү гарчихсан учраас бэлчээрийн даац хэрээс хэтэрчээ.

Үргэлжлэл нь III нүүрт









| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах | Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2430.00 | 2442.00 | ФУНТ | 3100.00 | 3177.00 | АМ.ДОЛЛАР | 2428.00 | 2442.00 | ФУНТ | 3106.00 | 3182.00 |
| ЕВРО | 2862.00 | 2922.00 | РУБЛЬ | 41.20 | 43.10 | ЕВРО | 2868.00 | 2928.00 | РУБЛЬ | 41.24 | 43.50 |
| ИЕН | 22.05 | 22.53 | ЮАНЬ | 369.00 | 374.00 | ИЕН | 21.88 | 22.47 | ЮАНЬ | 369.00 | 374.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

АЙЛЧЛАЛ

# ОХУ-ААР ДАМЖИН ТАВАНТОЛГОЙН НҮҮРС ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРНА ГЭВ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Дорнын эдийн засгийн форум өнөөдөр, маргааш хоёр өдөр үргэлжлэх бөгөөд мөн энэ хугацаанд дээрх албан уулзалтуудаас гадна Япон, ОХУ-ын бизнесийн төлөөлөлтэй уулзахаар болжээ. Тэгвэл өчигдөр Х.Баттулга Ерөнхийлөгч дагалдан яваа хүмүүсийн хамт ОХУ-ын Восточный далайн боомтын үйл ажиллагаатай танилцлаа. Ерөнхийлөгч тус боомтын нүүрс буулгалтын үйл ажиллагаа, Техникийн удирдлагын нэгдсэн төв, Төмөр замын шинэ станцын бүтээн байгуулалт зэрэгтэй танилцсаныг Ерөнхийлөгчийн хэвлэл мэдээллийн албанаас мэдээлсэн юм. Восточный боомт нь ОХУ-ын хамгийн том далайн терминал бөгөөд нүүрс, чингэлэг, мод, ашигт малтмал, химийн ачаа, газрын тос зэрэг ачаа голлон тээвэрлэдэг бөгөөд нийт боловсруулсан бараа бүтээгдэхүүний 99 хувийг Номхон далайн бүсийн орнууд болох Өмнөд Солонгос, Япон, Хятад руу тээвэрлэдэг байна. Тэгвэл энэхүү боомтыг ашиглан Монгол Улс өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ гуравдагч зах зээлд гаргах боломжтой талаар харилцан санал солилцож, транзит гэрээ байгуулахаар болсныг Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга З.Энхболд мэдэгдлээ. Тэрбээр, өөрийн твиттер хуудсандаа “ОХУ-ын Восточный порт. Нүүрс ачдаг. Манай Тавантолгойн нүүрсийг дэлхийн зах зээл дээр гаргахад туслахаар боллоо. Транзит гэрээ байгуулна” хэмээн жиргэжээ. Монгол Улсын хувьд нүүрсний баялаг нөөцтэй ч зах зээл хязгаарлагдмал, нэг улсаас хараат байдалтай олон жил явсан. Зөвхөн БНХАУ руу гаргадаг бөгөөд тус улсын Чалко компанитай байгуулсан гэрээ, зээлсэн мөнгөний улмаас тонн нүүрсээ хамгийн хямдаар өмнөд хөрш рүү олон жил зөөсөн нь худлаа биш. 2011-2016 оны хугацаанд 24.4 сая тонн нүүрсийг тонн тутам нь 30 ам.доллараар гаргаж, ямар ч ашиггүйгээр хил давуулж байсан тоон баримт ч бий. Тэгвэл Ерөнхийлөгчийн айлчлалын хүрээнд яригдсан энэхүү хамтын ажиллагаа биелэлээ олвол нэг улсаас хараат байдал арилж, бид хоёр хөршөөрөө дамжуулан Тавантолгойн нүүрсээ олон улсын зах зээлд гаргах боломж бүрдэх юм. Ингэж чадвал олон жил ярьж буй Тавантолгойн хувьцаа амь орж, монголчууд нүүрснээсээ ашиг хүртэх боломж бүрдэх нь ээ. Төрийн тэргүүний айлчлалаас хүлээж буй ээрэг хүлээлт эхнээсээ үр дүнгээ өгч эхлэв бололтой. Транзит тээврийн гэрээ үр дүнгээ өгч, эдийн засгийн коридор байгуулах ажил амжилттай хэрэгжиж эхэлсэн тохиолдолд дан ганц уул уурхайн бүтээгдэхүүн ч бус хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн ч гуравдагч зах зээлд гарах боломжтой. 2016 онд Монгол Улс 25.6 сая тонн нүүрс экспортолсон гэх тоон мэдээ бий. Энэ нь нийт хүчин чадлынхаа дөнгөж 40 гаруй хувийг ашигласан гэсэн үг.




Үлдсэн 60 хувийг ашиглаж чадахгүй байгаа нь хэд хэдэн шалтгаантай гэдгийг судлаачид хэлж байгаа юм. Хамгийн чухал нь тээвэрлэлт бөгөөд дан ганц автозамаар нүүрсээ хилээр гаргадаг, мөн хил гаалийн асуудлаа шийдэж чадаагүйгээс нүүрс ачсан машинууд Гашуунсухайт боомт дээр 150 гаруй км очер үүсгэж, хилээр гарахын тулд 2-3 хонодог зэрэг бэрхшээлтэй асуудлаас үүдэж нүүрсний зах зээл үндсэндээ уналтын байдалд хүрээд буй юм. Хөрөнгө оруулагчдын итгэл ч алхам алхмаар алга болж, уул уурхай уналтад орсон энэ үед хоёр хөрштэй хийж буй хамтын ажиллагааны шинэ яриа хэлцэл сэргэлт авчрах нь дамжиггүй билээ. Дэлхийн зах зээлд нүүрсний үнэ ойрын 2-3 жилдээ огцом унахгүй гэсэн судлаачдын дүгнэлтээс харвал монголын нүүрс эргээд моодонд орох нь дамжиггүй. Тэгэхийн тулд төмөр замын ажлаа ч эрчимжүүлэх бололтой.

Ингэж чадвал автозамаар тээвэрлэж буй алдагдал эргээд монголын ашиг болно. Восточный боомтоор дэлхийн зах зээлд гарах асуудлыг олон ч судлаачид үгүйсгэдэг. Ямар ч боломжгүй хэмээн олон жил эсэргүүцсэн. Гэтэл нөгөө талд боломж байгааг үндэслэл тооцоо гаргаж тайлбарлах хүмүүс ч олон бий. Восточный боомт хүртэл 5000 орчим км замыг автозамаар туулах уу, эсвэл төмөр зам тавих уу гэх мэтээр бэрхшээлтэй асуудал яригдах ч хоёр улсын төрийн тэргүүний өнөөдрийн уулзалт энэ бүхнийг шийдэх гарц гаргалгааг хайх биз ээ.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
*19 дэх жилдээ*

Ерөнхий эрхлэгч:
С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч
Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Э.ЭНХЦЭЦЭГ
90873012

Ахлах редактор:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба
Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:
Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:
Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:
Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:
М.ДАВААДУЛАМ
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн
Н.ПУНЦАГБОЛД

*Улсын бүртгэлийн дугаар: 907300528*
*Индекс: 100757*

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.**
**2 давхар. 209, 211 тоот**

**“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

ОНЦЛОХ УЛС ТӨР

# МАН-ын 31 тойрч зугтсаар...

Б.ЭРХЭС

Шадар сайд У.Хүрэлсүх тэргүүтэй МАН-ын 31 гишүүн Засгийн газраа огцруулах асуудлыг өргөн барьснаас хойш багагүй хугацаа өнгөрөөд байна. Өнгөрөгч долоо хоногт энэ асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, нэгхэн гишүүний зөрүүгээр огцруулах шаардлагагүй гэж үзсэн юм. Мөн энэ долоо хоногт МАН-ын Бага хурал хуралдаж, Засгийн газраа огцруулах уу гэдгийг хэлэлцэнэ гэсэн хүлээлт байсан ч даваа гарагт МАН-ын Удирдах зөвлөл хуралдаж огцруулах эсэхийг хэлэлцээд өнгөрлөө. Удирдах зөвлөлийн хурлаас Засгийн газраа тогтвортой ажиллуулах чиглэл өгч, улмаар өчигдөр МАН-ын бүлгээр хэлэлцэх байсан ч харамсалтай нь ирц хүрэхгүй хүлээсээр байлаа. Өчигдөр өглөө 11.00 цагт бүлгийн хуралдаан зарласан ч ирц хүрэхгүй байсаар үдээс хойш 15.00 цагт хуралдах зар тараав. Гэсэн ч 15.00 цагаас хойш мөн л ирц хүрэхгүй гацаж, цөөн хэдэн гишүүд хүлээж суулаа. Огцруулах албан бичигт гарын үсэг зурсан гишүүд хуралдаа суухгүй гүрийх, тойрч зугтах тохироонд хүрсэн тухай бор шувуу өчигдөр саарал ордонд нисэв. Түүнчлэн, Удирдах зөвлөлийн хурлыг огцруулах албан бичигт гарын үсэг зурсан гишүүд орхиж, үлдсэн гишүүд нь тэднийг намаас хөөх шийдвэр гаргасан талаар ч албан бус эх сурвалж мэдээллээ. Харин энэ мэдээлэл үнэн эсэхэд УИХ-ын гишүүд өөр өөрсдийн ойлголтоор хариулт өглөө. Тухайлбал, УИХ-ын гишүүн Н.Оюундарь Засгийн газар тогтвортой ажиллах ёстой гэсэн байр сууриас ухрахгүй гэсэн бол УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн “Засгийн газрыг огцруулах ёстой гэсэн байр сууриас ухрахгүй. Зарим гишүүд намын дүрмээ хэрэгжүүлнэ. Эсрэг санал өгсөн гишүүдийг намаасаа хөөнө гэж ярьсан байна лээ. Би хурлын дундаас гараад явчихсан. 65 гишүүнийхээ 33-ыг нь хөөчихөөд сууж байдаг нам гэж байх уу” хэмээн бухимдлаа. Энэ мэтээр МАН дотооддоо ойлголцолд хүрээгүй батлах олон ч үйл явдал өрнөж байна. “МАН-2021” гэх утаснаас УИХ-ын нэр бүхий гишүүд болон намын гишүүд дэмжигчид рүү “Эрхэм гишүүн.............АН-тай нэгдэн Засгийн газраа унагахаар санаархаж байна. Та энэ талаар саналаа .......... утсанд хэлнэ үү” гэх мэтээр гишүүдийн утасны дугаарыг олон нийтэд зарласан нь гишүүдийн дургүйцлийг төрүүлсэн гэхэд болно. Тиймдээ ч огцруулах бичигт Ч.Улаан, Сү.Батболд нарын гишүүд нэмэгдэж гарын үсэг зурсан гэх мэдээлэл өчигдөр цацагдсан юм. Харин Ч.Улаан гишүүн энэ мэдээллийг үгүйсгэж, хэнийх нь ч талд ороогүй гэх тайлбар өгсөн бол Сү.Батболд гишүүн одоогоор тайлбар өгөөгүй байна. Огцруулах бичигт гарын үсэг зурсан гишүүд тойрч зугтсаар шууд чуулганы хуралдаанд асуудлыг оруулж кноп дарах нь гэх хардлага ч гишүүдийн зүгээс гарч байлаа. Юутай ч чуулганы хуралдааны тов өнөөдөр гарсан бөгөөд хуралдах эсэхийг хүлээх л үлдлээ. Хуулийн хугацаа маргааш дуусах учиртай.

БАЙР СУУРЬ

# Г.БАТБААТАР: Анагаахын Их сургуулийн хотхоныг

Б.ӨНӨРТОГТОХ

*Анагаах шинжлэх ухааны, үндэсний их сургуулийн захирал Г.Батбаатартай цаг үеийн асуудлаар ярилцлаа.*

**-Монголын их, дээд сургуулиудаас АШУҮИС анхдагч болж нийслэл хотын хүн амын төвлөрөл, ачааллыг бууруулах талаар санал гарган оюутны хотхоноо нүүлгэх, шинэ хотхон байгуулах асуудлыг Засгийн газар ээлжит хуралдаанаараа авч хэлэлцэн дэмжихээр болсон. Асуудал цаасан дээр яригдаж байна уу эсвэл?**

-Их сургуулийн эмнэлэг барих асуудлыг АШУҮС-ийн үе үеийн удирдлагууд олон жил хөөцөлдсөний үр дүнд 2013 онд Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт найман га газар шийдэж өгсөн юм. Эмнэлгээ ингэж барина гэх мэтээр ярилцаж байгаад ер нь Их сургуулийн хотхон маягаар барих нь зөв юм байна гэсэн шийдэлд хүрсэн. Тэгээд хөрөнгө оруулагч нарынхаа дэмжлэг, туслалцаатайгаар зураг төслөө хийлгэсэн. Зураг төслийг боловсруулах үед бид “Их сургуулийн багш, оюутнууд шаардлагагүй тохиолдолд хотхоноос гадагшаа гарахгүй байх тийм орчин бүхий хотхон “ байх талаар санаа оноогоо тусгуулж, зургийг нь хийлгэсэн. Хүний өдөр тутмын амьдралд шаардлагатай бүх зүйлийг тэнд цогцоор шийднэ гэсэн үг. Сургууль, цэцэрлэг гэх мэтчилэн. Энэ бүхнийг цогцоор шийдсэн байхад манайхан хотын хөдөлгөөнд оролцож, ачаалал дээр ачаалал болохгүй шүү дээ. Мэдээж асар их хөрөнгө мөнгө шаардлагатай ч бидний саналыг маш олон хүн дэмжсэн. Зураг төсөл нь батлагдчихсан. Мөнгийг нь яаж босгох вэ гэсэн асуудал үүссэн. 200 гаруй тэрбум гэсэн урьдчилсан тооцоо бий. Японычууд 74 тэрбум төгрөгийг шийдэж өглөө. Их сургууль өөрөө 10 тэрбумыг гаргаад сургалтын эхний хэсгийг барьчихлаа. Засгийн газрын ээлжит хуралдаанаар асуудлыг маш сайн дэмжиж, 14.3 тэрбум төгрөгийг 2018 оны төсөвт суулгахаар шийдвэр гаргалаа. Ажил маань урагштай яваад сургуулийн хамт олон баяртай байгаа. Их сургуулийн цогцолбор баригдсаны дараа оюутны байр, эмнэлэг, багш ажилчдын байр барих асуудлаа шийднэ. Дөнгөж өчигдөр Их сургуулийн зөвлөлийн хурлаар оюутны байрыг барих нь зүйтэй гэж үзлээ. Нийслэлд 150 мянган оюутан аж төрдөг гэсэн тооцоо бий. Хотын түгжрэл, замын хөдөлгөөнд энэ 150 мянган оюутан ачаалал дээр ачаалал болдог нь тодорхой. Намрын намарт сургууль, цэцэрлэгийн хичээлийн шинэ жил эхлэхээр ачаалал нэмэгддэг шүү дээ. Тэгэхээр 100 мянган оюутнаас ядахдаа 12 мянгыг нь Их сургуулийн хотхонд амьдруулчихвал ачаалал тэр хэрээр багасч таарна. Мөн 1000 гаруй багш ажилчид хотхон дотроо байранд амьдраад өглөө ажилдаа унаагүйгээр очоод, хажуу талд нь цэцэрлэгт хүүхдээ өгчихөөд байвал мөн л тэр хэмжээгээр ачаалал багасна. Их сургуулийн хотхоны ач холбогдол иймүү. Өчигдөрхөн Хотын захирагч Су.Батболд дарга их,дээд сургуулийг хотоос гаргах санаачилга гаргаснаа танилцуулж байна лээ. Бид эл санал санаачлагыг баяртайгаар хүлээж авсан. Наймдугаар сарын 31-ний Засгийн газрын хуралдааны үеэр Боловсролын сайдад мөн Ерөнхий сайд үүрэг чиглэл өгсөн. Энэ мэтээр ажил хэрэг маань урагштай явна.

**-Хугацааг хэдийгээр гэж тооцож байна. Ойрын жилүүдэд ашиглалтад оруулж чадах уу?**

-Бид 2019 оны сүүл, 2020 оны эхний улиралд ашиглалтад оруулна гэсэн төлөвлөгөө гаргаад явж байна. Хамгийн сүүлийн хугацаа нь 2020 оны гуравдугаар сарын 1 гэхэд Их сургуулийн хотхоныг ашиглалтад оруулна. Манай сургууль олон газар салбартай. Энэ бүх салбар нэг дор ирчихээр тэр хэмжээгээр ачаалал буурна. Төрд энэ өмчийг нь буцаагаад өгнө. Ер нь асуудлаа сайн ойлгуулж чадвал дэмжих хүн олон байдгийг өнгөрсөн гурван жилийн хугацаанд маш сайн ойлголоо. Гадны хөрөнгийг зөв татаж, байршуулж болно гэдгийг ойлгосон. Хамгийн гол нь үүнийгээ нээлттэй, зөв зохион байгуулах л ажил байдаг юм билээ. Ирэх жил бид 1000 оюутны байраа барина. Тэр хөрөнгөө босгочихсон гэж ойлгож болно. Арслантай гүүрний цаана манай сургуулийн оюутны хоёр ч том байр бий. Хичээлийн байр гэж их том газартай, дөрвөн давхар том обьект байна.Бид хэрвээ шинэ хотхоноо барьчихвал энэ бүгдийг төрд хүлээлгэж өгнө. Дуудлага худалдаанд оруулна уу, эсвэл сургуулийн цэцэрлэгийн зориулалтаар ашиглана уу, нураагаад шинэ юм барих нь уу гэдэг нь төрийн хэрэг. Ямартай ч 2018 оны төгсгөлөөр хичээлийн шинэ байраа бүрэн ашиглалтад өгнө. Гуравдугаар эмнэлгийн ард байгаа сувилахуйн сургуулийн хичээлийн байр, Нүүр ам судлал, Эмзүйн сургалтын байр гэх мэтээр маш олон байрууд суларна. Мөн л төрд хүлээлгэж өгнө. Төр эдгээрийг зориулалтынх нь дагуу ашиглах биз. Тухайлбал, Улаанбаатар хотын шүдний төв өөрийн гэсэн байр байхгүй. Тэр байгууллага тухайлбал манай сургуулийн нэг байранд орж болно. Эсвэл шинэ сургууль, цэцэрлэг оруулчихсан ч болно. Дахиад хэлэхэд, бид төрөөс дандаа тусламж гуйдаг байж болохгүй шүү дээ. Боломж нь байвал нэмэр болдог байх ёстой. Төрийн дэмжлэгээр шинэ

## ҮЗЭЛ БОДОЛ





# МАЛЧИН, ТАРИАЛАНЧ ХОЁР ЗОДОЛДОЖ Л БАЙГ УУ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Газар тариалангийн бүс нутаг гэгдэх Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Төв аймгуудад бэлчээрийн даац 2-15 дахин нэмэгдсэн гэсэн тоон мэдээ байна. Бүр бэлчээрийн газар авахын тулд сумын Засаг даргынхаа үүдийг хэдэн өдөр сахиж суугаа талаар ч нутгийн иргэд ярьж байлаа. Нэг талаар инээдэм, нөгөө талаар эмгэнэл гэхээс өөр яалтай.

...“Буянт малаа ад үзсэн хар шороо ухсан гуйлгачид” гэх мэтээр нутгийн хоёр буурай хэрэлдэж суухыг ч өөрийн нүдээр харж байлаа. Миний танил шиг олон хүн тариалангийн газар нутагт амьдрахын тулд малаа зарж, үгүй хийх үү, эсвэл бэлчээр хайж нутаг орноосоо нүүх үү гэдэг сонголт хийхэд хүрч байгааг төр засаг анхаарлаа хандуулах цаг нь болчихож...

Хөдөө орон нутагт малчин, тариаланч хоёрын хэрүүл мөнхөд үргэлжлэх хэрэг үү. Сумын Засаг дарга нар захирамж гаргаж намар, хавар, зундаа газар тариалангийн талбайд малаа ойртуулж болохгүй. Тариаланчид хашаа заавал барих ёстой гэх мэтээр журам дүрмээр зохицуулахыг хичээдэг ч бэлчээрийн мал тэр тусмаа адууг хашч, хорих боломж тэр болгон байхгүй юм билээ. Худал хэлсэн хүнд ах дүү, амраг садан хүртэл хэрэлдэж зодолдохдоо хүрч байх юм. Газар тариалангийн талбайн 40 орчим хувийг зөвхөн мал тахалдаг гэсэн тоон мэдээ ч бий. Үүнээс болж тариаланчид талбайгаа тойруулж газар ухдаг, эсвэл талбайнд орж ирсэн малыг зодож, хүндээр шархлуулдаг, нүхэнд унасан мал нь гэмтдэг, үхдэг, малчдаас аманд орсон мөнгөө нэхдэг гэх мэт асуудал улам бүр даамжирсаар эцэстээ эрүүгийн хэрэг ч гарч эхэлснийг дуулгая. “Буянт малаа ад үзсэн хар шороо ухсан гуйлгачид” гэх мэтээр нутгийн хоёр буурай хэрэлдэж суухыг ч өөрийн нүдээр харж байлаа. Миний танил шиг олон хүн тариалангийн газар нутагт амьдрахын тулд малаа зарж, үгүй хийх үү, эсвэл бэлчээр хайж нутаг орноосоо нүүх үү гэдэг сонголт хийхэд хүрч байгааг төр засаг анхаарлаа хандуулах цаг нь болчихож. Үүнд дан ганц салбар яамыг харж суух нь утгагүй. Тэд хуулийн дагуу л ажилладаг. Газар тариалангийн хуулийн дагуу ажиллахыг чухалчилж, аль нэг талд нь үйлчлэхгүйгээр шийдвэр гаргахыг хичээдэг ч энэ шийдвэрээс аль нэг нь заавал хохирол амсах нь тодорхой юм. Миний танилын амьдардаг Төв аймгийн Жаргалант сум Монголын төмс хүнсний ногооны 40 гаруй хувийг хангадаг. Гэтэл энэ сум мөн л бэлчээрийн мал аж ахуйтай. Хэрвээ төр шийдвэр гаргаад, үйлдвэрийн бодлогоо зөв хэрэгжүүлж газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг дэмжээд явчихвал, хэн хэн нь асуудлаа төвөггүйхэн шийдээд явчихна.

Иргэд дургүйцсэн зүйл огт байхгүй. Харин ч дэмжиж байгаа гэдгээ удаа дараа төрд уламжилдаг ч Монголын төр малчин, тариаланч хоёроо зодолдуулаад мартаж орхижээ. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн хувьд тариаланч, малчид хоёрын маргаан мөн л толгойн өвчин болоод байгаа аж. Тус аймгийн бэлчээрийн даац 2.8 хувиар хэтэрсэн бөгөөд бэлчээрийн мал аж ахуйтай учраас мал уриншилсан талбайд орж хөрс нягтруулах, хөрсний бүтцийг алдагдуулснаас ургацын хэмжээ буурч, буудайн хангалтад сөрөг нөлөө үзүүлж эхэлсэн гэнэ лээ. Тиймдээ ч бэлчээрийн мал аж ахуйн асуудлыг энэ аймагт нэг мөсөн цэгцэлж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, малын тоо толгойг бууруулах зэрэг нэгдсэн бодлого хэрэгтэй байгааг аймаг орон нутгийн удирдлагууд ярьсаар байх юм. Игэдийн 80 гаруй хувь нь үүнийг дэмжсэн. Харамсалтай нь төрийн бодлого гарсангүй. ХХААХҮ-ийн яамны хэрэгжүүлж буй бодлогыг дорвитойхон дэмжиж, “Үйлдвэржилт-21:100” хөтөлбөрийг цаг алдахгүй хэрэгжүүлж эхэлвэл, бүсчлээд өгчихвөл энэ маргаанд бид цэг тавих учиртай юм. Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт атрын гуравдугаар аяныг үргэлжлүүлэх томоохон зорилт багтаж буй. Гэвч газар тариалангийн бүс нутгаа ангилж, малчин, тариаланчийнхаа бэлчээр, тариан талбайн маргааныг шийдээгүй цагт энэ хөтөлбөр бодитоор хэрэгжих эсэхийг хэлэхэд эрт. Төрийн бодлогыг нэг яаманд даатгаад орхих бус хэрэгжүүлэх боломжийг нь хангах талаас хууль эрхзүйн орчныг нь батлаад өгчихдөг бол буянт малаа буудаж ална хэмээн дөвчигнөж суухгүй л байлтай. Хэдий болтол сумдын Засаг дарга, салбар яам хэрүүл зохицуулах хэрэг вэ, улстөрчид өө.

# сургууль анхдагч болж хотоос гадна барина



сургууль, хотхоноо барьчихвал бүх байраа төрд өгнө. Бусад их, дээд сургуулиудад ч ийм боломж бий. Заавал хотын төвд сургуультай байна гэж улайрч яах юм. Өөрсдөө жаахан томхон сэтгэж, хөрөнгө оруулагчаа татаад, хаана ямар зүйл дээр дэмжлэг авч болох вэ гээд зүтгэвэл болохгүй зүйл байдаггүй юм байна. Жишиг хотхон байгуулж болдог юм гэдгийг харуулахыг хүссэн юм. Засгийн газар бидний хүсэлтийг хүлээн авч, дэмжиж байгаад маш их баярлаж байгаа. Бид байгуулж чадна гэсэн урам зоригтойгоор ажиллаж байна даа.

**-2017-2018 оны хичээлийн шинэ жил эхэллээ. Мэдээж өндөр ачаалалтай ажиллаж буй нь тодорхой. Их сургуулийн цогцолбор гэсэн том ажлын хажуугаар оюутан залуусынхаа сурах орчныг бүрдүүлэх, сурлагын чанарт анхаарах, шинэчлэл өөрчлөлт хийх гэх мэт олон ажлууд бий.**

-Эрдмийн байгууллага гэдэг тухайн нийгмийнхээ хамгийн оюунлаг хэсэг. Тэр утгаараа тогтвортой хөгжлийн бодлогоо тодорхойлж, тэрнийхээ дагуу л ажиллаж байна. 2015-2024 онд Их сургуулийн хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөг Удирдах зөвлөл баталсан. Өнгөрсөн хичээлийн жилд Хүний их эмч бэлтгэх хөтөлбөртөө олон улсын магадлан итгэмжлэл хийлгэчихлээ. Харин энэ оны аравдугаар сард сувилагч бэлтгэх хөтөлбөрөө олон улсын магадлан итгэмжлэлд оруулна. Мөн Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг урьдчилсан байдлаар олон улсын магадлан итгэмжлэлд оруулсан гэх мэтээр хөтөлбөрийн шинэчлэлийг яриад байвал олон зүйл бий. Энэ бүхэн АШУҮИС-ийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг олон улс хүлээн зөвшөөрлөө гэсэн үг. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүх орчныг бид өнгөрсөн хугацаанд бүрдүүлж чадсан. Манайх олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлж чадна аа гэсэн баталгааг гаргаад өгөхөөр бусад улс орнууд ч манай их сургуулийн төгсөгчдийг эргэлзэх зүйлгүйгээр хүлээн зөвшөөрдөг юм байна. Магадлан итгэмжлэл хийлгээгүй хөтөлбөрөөр хичээл орвол бусад улс орнууд манай Их эмч нарыг ямар хичээл заалгаад юу сураад ирснийг ойлгохгүй, хүлээн зөвшөөрөхгүй. Одоо бол мэргэжлээрээ ажиллах, тухайн чиглэлээр дараа дараагийн сургуульд суралцах бүрэн боломжтой болсон. Бид шинэ юм туршаад, өөрсдөө сэдээд байгаа юм шиг. Их сургууль яаж хөгждөг вэ гэсэн бэлээхэн туршлагыг харж байгаад л тэдгээр сургуулиудын өмнө нь туулсан бэрхшээлийг товчилж, илүү хурдан хугацаанд шинэ төвшинд хүрэхийг зорьж буй хэрэг. Мөн оюутны сурах орчныг сайжруулах талаар нэлээдгүй ажил хийж байгаа. Тухайлбал, манай сургууль Японы “Токио Ариакэ” их сургуультай хамтран Уламжлалт анагаахын мэс засалч гэх мэргэжлээр боловсон хүчин бэлтгэхээр болж, тус сургуулийн удирдлагууд манай сургууль дээр ажиллаж байна. Шинэ эмнэлэгт маань Спортын гэмтлийн тасаг шинээр байгуулж өгөхөөр болж эхний багаж тоног төхөөрөмжийг өнөөдөр бидэнд гардууллаа. 60 гаруй сая төгрөгийн тоног төхөөрөмж эхний удаад ирлээ. Бид тэдэнд бодит байдлаа л танилцуулсан. Хамтарч ажиллах боломж, юунд зорьсноо ойлгуулчихад тусалж дэмжиж, хамтарч ажилладаг юм байна. Зүгээр царай алдаж гуйх өөр хэрэг. Боломж бололцоо, хамтын ажиллагааг яриад очих шал өөр шүү. Эрдэм шинжилгээний салбарт ургац арвин гэж дүгнэж болно. Анагаахын шинжлэх ухааны, үндэсний их сургууль гэсэн хаягтайгаар анх удаа, түүхэндээ хоёр удаа дэлхийн бүх эрдэмтэн, судлаачдын мөрөөдөл болсон анагаах ухааны салбарын том сэтгүүлд хоёр эрдэм шинжилгээний нийтлэл хэвлүүлчихлээ. Энэ чинь дэлхийн том эрдэмтэн судлаачдын анхаарал манайхыг чиглэнэ гэсэн үг. Судлаач руу маань ч хандаад эхэлсэн. Манай сэтгүүлд нийтлэлээ өгөөч, энэ сэдвээр нийтлэл бичээд өгөөч гэх мэтээр хандаж байна. Бид Японы” Рикэн” гэх судалгааны том байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, хөрөнгө санхүүгээ хамтран гаргаад судалгааны ажлаа хэрэгжүүлж байгаа. Энэ бол манай судлаачдын бүтээл дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, дэлхий биднийг харах цаг ойрхон ирснийг харуулж буй юм. Цаашлаад БСШУС-ын яамны дэмжлэгээр багш нараа чадавхжуулах ажлыг ч эрчимтэй хийнэ. Өөрөөр хэлбэл, Харвардын программаар манай сургууль болон эмч, эмнэлгийн ажилтныг бэлтгэнэ. Мөн энэ онд 100 гаруй багшийг сургалтад хамруулахаар болсон. Энэ оны аравдугаар сард сургалтаа эхлүүлнэ. Хэрвээ амжилттай болвол Монголын их, дээд сургуулийн 100 эмч Харвардын их сургуулийн диплом, сертификаттай болох юм. Багш нар маань хичээх л үлдэж байна. Ер нь манай сургууль багш нараасаа чадвартай байхыг шаарддаг. Хэлний боловсролтой байхыг чухалчилдаг. Яагаад гэвэл манай сургуульд маш олон гадны төсөл хөтөлбөр хэрэгждэг. Багш нарынхаа хөгжил, чадварын төлөө хэдэн мянган ам.доллар үрж сургахыг хичээж буй учраас тэд маань хариуцлагатай байж сурах зүйлээ сурч авах л ёстой гэсэн шаардлага тавьдаг. Би үүнийг багш нартай хэлдэг. Голланд, Канад зэрэг олон улсын томоохон төсөл хөтөлбөр, сургалтууд манайд хэрэгжиж байгаа.

## Дугаарын 60 мөр

### Нэг хашаанд нэг л яндан байлгая

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Уг нь иргэдийг орон сууцжуулбал утаа алга болох ёстой. Мөн гэр хорооллыг төвийн шугамд холбоод, гал түлэхгүй болчихвол утаа багасна. Үнэн гэвэл энэ. Гэхдээ манай төр засгийнхан тийм ажил хийхгүй нь тодорхой. Утаа алга болчихвол зуух шахах бизнесгүй болоод тэд маань ядуурч гүйцэнэ шүү дээ. Тийм болохоор ойрын хэдэн жилдээ зуух, яндангаа яриад явах байх. Хэрвээ манай төр засгийн удирдлагууд иргэдээ бодсон бол арай өөр бодлого баримтлах байлаа. Тухайлбал, нэг хашаанд нэг л яндан байхаар журамлаад өгчихдөг бол хэрэгтэй. Эртнээс ийм журам гаргаад, хөдөөнөөс орж ирж байгаа иргэдэд заавал өөрийн орон сууцтай, эсвэл хашаатай байх шаардлага тавьж байсан бол хотын утаа одоогийнхоос 3-4 дахин бага байх байсан талаар судлаачид хэлж л байна. Иргэд сайндаа хот руу нүүгээгүй. Ядуурсан учраас ажилтай, амьдралтайг нь бодож нийслэл рүү нүүж байгаа. Тийм хүмүүст юуных нь хашаа авах мөнгө байдаг юм гэж хэлэх хүмүүс олон гарна. Тийм ээ, үнэн. Одоогийн байгаа байдал үнэхээр тийм байгаа. Гэхдээ энэ чинь бүхэл бүтэн улс байна даа. Гуравхан сая иргэнийх нь тал хувь нь нийслэлд шавж, утаандаа нийтээрээ хордож байснаас арай өөр гарц бидэнд хэрэгтэй биз дээ. Одоо ч гэсэн нэг хашаа, нэг яндан гэсэн журам гаргамаар байгаа юм. Улаанбаатарт нэг хашаанд 4, 5 айл байх ч тохиолдол зөндөө л байна. Аль болох төв рүүгээ ойрхон байх гээд л нэг хашаанд шавааралдчихдаг. Одоо ч гэсэн хөдөөнөөс хот руу чиглэсэн нүүдэл байдгаараа л байгаа. Тэдний ихэнх нь Улаанбаатарт байгаа танил тал, хамаатан садныхаа хашаанд буухаар зүтгэж байгаа шүү дээ. Ядаж энэ урсгалыг ч гэсэн зогсоомоор байна. Хэдийгээр хүн хаана амьдрах нь эрхийн асуудал. Гэхдээ цөөн хүний эрхээр олон хүнийхийг зөрчиж бас боломгүй. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээс хүн хаана амьдрахаа дураараа сонгож болох нь илүү гэж хэн хэлээд байгаа юм. Тийм болохоор яаралтай арга хэмжээ авах цаг болсон. Нэг хашаанд 4, 5-аараа байгаа айлуудыг ч гэсэн зохицуулах хэрэгтэй байна. Зарим боломжтойг нь гал түлэхгүй, халаалтаа өөр аргаар шийдэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн ч яадаг юм. Яаж нэг хашаанд нэг яндан байлгаж болох вэ, боломж юу байна гэдгийг ч судлах л хэрэгтэй байна. Мөн орон сууцжуулах хөтөлбөрөө ч сайтар хэрэгжүүлье. Тэр дундаа бага, дунд орлоготой иргэд рүү чиглэсэн төсөл хөтөлбөр хэрэгтэй байна. Ингэж чадвал утаа бага ч болов буурна. Хятадтай орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлэхээр гэрээ хэлэлцээр хийж байгаа талаар нэг хэсэг мэдээлэл гарсан. Тэр хэлэлцээр нь хаанаа гацчихав. Уг нь утаанаас салах бүхий л аргыг бид хэрэглэмээр байгаа юм. Одоо утаагаар бизнес хийхээ больчих хэрэгтэй шүү дээ, эрхэм дарга нар минь. Нэг удаа ч болов иргэдийнхээ төлөө шийдвэр гаргаад, зоригтойхон хөдлөх хэрэгтэй байна аа.

## МЭДЭЭЛЭЛ

# АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН 2017 ОНЫ 8 ДУГААР САРЫН ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭ

### Шинээр олгосон ашиглалтын тусгай зөвшөөрөл

| № | Тусгай зөвшөөрлийн дугаар | Аймаг / хот | Сум / дүүрэг | Талбайн нэр | Талбайн хэмжээ (га) | Эзэмшигч | Эзэмшигчийн регистр # | Шийдвэрийн огноо | Шийдвэр # | Олгосон огноо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | MV-020889 | Төв | Баян | Цагаан өндөр | 504,50 | Баярсконстракшн | 2061899 | 2017.07.26 | 436 | 2017.08.09 |
| 2 | MV-020893 | Булган | Бүрэгхангай | Улаануул | 80,19 | Мон хуа энерги | 6134335 | 2017.08.25 | 520 | 2017.08.25 |
| 3 | MV-020894 | Сэлэнгэ | Орхонтуул | Өлзийт | 77,92 | Магнет-Айрон | 4257456 | 2017.08.25 | 521 | 2017.08.25 |
| 4 | MV-020898 | Улаанбаатар | Багануур | Цвраа толгой | 410,61 | Монголстандарт | 2771799 | 2017.08.25 | 522 | 2017.08.31 |
| 5 | MV-020899 | Дундговь | Баянжаргалан | Хөөт | 65,33 | Хуучин-Андууд | 2668505 | 2017.08.31 | 531 | 2017.09.01 |
| 6 | MV-020902 | Дорнод | Халхгол | Модон | 1 745,74 | Талын эрдэс | 5857872 | 2017.08.31 | 532 | 2017.09.01 |

### Шилжүүлсэн тусгай зөвшөөрөл

| д/д | Тусгай зөвшөөрлийн дугаар | Аймаг | Сум | Талбайн нэр | Талбайн хэмжээ | Шилжүүлсэн хэлбэр | Эзэмшигч | “Эзэмшигчийн Регистр” | “Шинэ эзэмшигчийн нэр” | Шинэ эзэмшигчийн регистрийн дугаар | “Шийдвэрийн огноо” | “Шийдвэрийн дугаар” |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | MV-011702 | Дорноговь | Айраг | Алаг толгой-1 | 37,78 | Бүхэлд нь | Дэрбумба | 2866234 | Их монгол жонш | 6171834 | 2017.08.21 | 493 |
| 2 | XV-012589 | Сүхбаатар | Сүхбаатар | Бухт | 1 184,36 | Бүхэлд нь | Эф Эм Ай | 5209552 | Буянт орд эрдэнэ | 5334853 | 2017.08.09 | 485 |
| 3 | MV-018652 | Булган | Дашинчилэн | Доргонот, Улаан ухаа | 269,28 | Бүхэлд нь | Батбродерс | 5117178 | Батбродерс майнинг | 6192939 | 2017.08.25 | 518 |
| 4 | XV-019414 | Дорноговь | Алтанширээ | Хар-Овоо | 3 401,02 | Бүхэлд нь | Монголиан прожект менежмент групп | 5730759 | ЧДМ | 6166318 | 2017.08.21 | 494 |
| 5 | MV-020442 | Архангай | Цэнхэр | Өлийн гол-1 | 1 500,51 | Бүхэлд нь | Батбродерс | 5117178 | Улз групп | 6183506 | 2017.08.09 | 484 |
| 6 | XV-020865 | Дорноговь | Дэлгэрэх | Баянтал | 8 269,78 | Бүхэлд нь | Инфинитиспэйс | 5467268 | Винд майнинг | 6168019 | 2017.08.16 | 492 |

### Хүчин төгөлдөр байх хугацааг сунгасан тусгай зөвшөөрөл

| Д/д | Тусгай зөвшөөрлийн дугаар | Аймаг | Сум | Талбайн нэр | “Тухайн суманд хамаарах талбайн хэмжээ” | Эзэмшигч | “Эзэмшигчийн регистрийн дугаар” | Сунгасан огноо | “Шийдвэрийн огноо” | “Шийдвэрийн дугаар” |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | XV-012730 | Төв | Угтаалцайдам | Халиун | 7 240,29 | Лхагважин | 2823616 | 2020.09.15 | 2017.08.22 | 499 |
| 2 | XV-013801 | Төв | Баян | Дэндгэр овоо | 649,98 | СТБЛ | 2762463 | 2020.06.12 | 2017.08.23 | 509 |
| 3 | XV-013930 | Хэнтий | Цэнхэрмандал | Мандал | 351,99 | Фэско | 5196183 | 2020.07.28 | 2017.08.31 | 536 |
| 4 | XV-013934 | Хөвсгөл | Галт | Бумбатын өндөр уул | 3 468,07 | Дасмондрилл | 5094887 | 2020.07.28 | 2017.08.31 | 536 |
| 5 | XV-014030 | Төв | Баянжаргалан | Жаргалант | 2 223,93 | Геомастер | 2630478 | 2020.08.20 | 2017.08.22 | 499 |
| 6 | XV-014055 | Дорноговь | Даланжаргалан | Улаан хэц | 406,46 | Улаанхэцийн шанд | 5427967 | 2020.08.25 | 2017.08.02 | 475 |
| 7 | XV-014063 | Говь-Алтай | Тайшир | Алтангадас | 368,53 | Аз макс | 2634015 | 2020.04.25 | 2017.08.21 | 496 |
| 8 | XV-014066 | Ховд | Дуут | Дуут | 11 572,97 | Содмаргад | 5032938 | 2020.08.28 | 2017.08.21 | 498 |
| 9 | XV-014070 | Дундговь | Гурвансайхан | Гургалдай | 1 493,60 | Жи Эн Ти Эл | 5157641 | 2020.08.28 | 2017.08.07 | 479 |
| 10 | XV-014105 | Хэнтий | Баян-Адрага | Хүүш | 651,27 | Сауд гоби блейк гоулд | 5358264 | 2020.09.04 | 2017.08.02 | 475 |
| 11 | XV-014108 | Баянхонгор | Баян-Өндөр | Хонгор-1 | 2 168,94 | Топазстоне майнинг | 5185181 | 2020.09.04 | 2017.08.11 | 489 |
| | | | Шинэжинст | | 67 781,79 | | | | | |
| 12 | XV-014126 | Дундговь | Өлзийт | Бор толгой | 9 245,88 | Шинэлонгда | 5164621 | 2020.09.09 | 2017.08.23 | 508 |
| 13 | XV-014132 | Баянхонгор | Баян-Өндөр | Хонгор | 4 271,75 | Топазстоне майнинг | 5185181 | 2020.09.09 | 2017.08.21 | 498 |
| | | | Шинэжинст | | 769,23 | | | | | |
| 14 | XV-014139 | Дундговь | Дэлгэрхангай | Эндэг улаан | 135,39 | ЦЕТ | 2600161 | 2020.09.09 | 2017.08.21 | 497 |
| 15 | XV-014140 | Төв | Баян | Гашууны тал | 0,04 | ЦЕТ | 2600161 | 2020.09.09 | 2017.08.09 | 482 |
| | | Улаанбаатар | Багахангай | | 58,99 | | | | | |
| 16 | XV-014148 | Сүхбаатар | Түвшинширээ | Төгөл | 39,55 | Ихтүмэн бээр | 5495369 | 2020.09.11 | 2017.08.23 | 508 |
| 17 | XV-014152 | Ховд | Үенч | Загт | 8 136,56 | Дүүлэх шонхор | 2160757 | 2020.09.11 | 2017.08.21 | 497 |
| 18 | XV-014154 | Дундговь | Эрдэнэдалай | Цагаан овоо | 398,36 | Окслейгоулд | 5489601 | 2020.09.11 | 2017.08.09 | 482 |
| 19 | XV-014177 | Баянхонгор | Бууцагаан | Салхитын ам-1 | 7 461,85 | Хонгорхангай эрдэнэс | 5297052 | 2020.09.22 | 2017.08.28 | 528 |
| | | | Хүрээмарал | | 62 416,23 | | | | | |
| 20 | XV-014192 | Дундговь | Эрдэнэдалай | Хөх овоо | 6 718,07 | Ньютиара | 5092744 | 2020.09.23 | 2017.08.23 | 509 |
| 21 | XV-014201 | Өмнөговь | Манлай | Улаан тойром | 507,13 | Нутгийн гантиг | 5198003 | 2020.09.24 | 2017.08.25 | 524 |
| 22 | XV-014231 | Дорноговь | Их хэт | Цагаан дэл | 109,17 | Баян өлзийт болд | 3307085 | 2020.09.30 | 2017.08.31 | 536 |
| 23 | XV-016856 | Дорноговь | Мандах | Могойт худаг | 875,60 | Шимтогтуун | 5195608 | 2020.08.28 | 2017.08.24 | 514 |
| 24 | XV-016992 | Дорноговь | Мандах | Могойт худаг | 1 080,48 | Их наран уул | 5626412 | 2020.08.28 | 2017.08.02 | 475 |
| 25 | XV-017145 | Увс | Өмнөговь | Хорхойтын зааг | 16,42 | Эс Пи Жи | 5428904 | 2020.09.22 | 2017.08.11 | 489 |
| | | | Тариалан | | 1 424,85 | | | | | |
| 26 | XV-020867 | Дундговь | Гурвансайхан | Гургалдай | 1 432,31 | Жи Эн Ти Эл | 5157641 | 2020.08.28 | 2017.08.07 | 479 |

### Дуусгавар болсон

| Д/д | Тусгай зөвшөөрлийн дугаар | Аймаг | Сум | Талбайн нэр | Эзэмшигч | “Эзэмшигчийн Регистрийн дугаар” | Үндэслэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 41 | XB-013961 | Дархан-Уул | Шарынгол, Хонгор | Хар ямаат | Дадизи юиан | 5179173 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 42 | XB-013980 | Дорноговь | Алтанширээ | Цогт | Орчлон-Орд | 5152054 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 43 | XB-013975 | Дорноговь | Даланжаргалан, Айраг | Ухаа | Талстбурхант | 5215331 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 44 | XB-014068 | Дорноговь | Даланжаргалан | Сайн гашуун | Шимзориг | 5195578 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 45 | XB-005635 | Дорноговь | Сайншанд, Сайхандулаан | Өндөр жавхлан | Фрийгүүд эрин | 5298679 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 46 | XB-014060 | Дундговь | Гурвансайхан | Уул жас | Шимдэлэг | 5195446 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 47 | XB-013950 | Сэлэнгэ | Ерөө | Их өлөнт-2 | Бөгт-ирээдүй | 5056519 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 48 | XB-014073 | Сэлэнгэ | Орхонтуул | Тавгийн шар | Азияферрум | 5210232 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 49 | XB-007151 | Төв | Баян | Цагаан өндөр | Баярсконстракшн | 2061899 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 50 | XB-010326 | Төв | Заамар | Тосонгийн гол | Сутайцэнд | 5047706 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 51 | XB-014939 | | Бөхмөрөн | Индэрт | Тефис майнинг | 2807459 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 52 | XB-008073 | Увс | Бөхмөрөн | Индэрт-2 | Тефис майнинг | 2807459 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 53 | XB-020878 | Увс | Бөхмөрөн | Индэрт-2 | Тефис майнинг | 2807459 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 54 | XB-020876 | Увс | Ховд, Бөхмөрөн | Индэрт | Тефис майнинг | 2807459 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 55 | XB-013682 | | Хан-Уул | Цагаан хөндий | МВС | 2637731 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 56 | XB-013422 | Улаанбаатар | Хан-Уул | Гишүүн-2 | Хера-Инвестмент | 2787687 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 57 | XB-014037 | Ховд | Алтай | Шар булаг | ВАБК | 5210941 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 58 | XB-014038 | Ховд | Алтай | Ганц мод | ВАБК | 5210941 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |
| 59 | XV-013958 | Хөвсгөл | Бүрэнтогтох | Мөрөн | Блэкрок | 5150167 | АМТ хуулийн 53.1.1-д заасан үндэслэлээр |

### Талбайг буцаан өгсөн

| № | Тусгай зөвшөөрлийн дугаар | Аймаг / хот | Сум / дүүрэг | Талбайн нэр | Буцаасан талбайн хэмжээ (га) | Буцаасан хэлбэр | Эзэмшигч | Эзэмшигчийн регистр # | Шийдвэрийн огноо | Шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | XV-014192 | Дундговь | Сайхан-Овоо | Хөх овоо | 1 134,30 | Тодорхой хэсгийг | Ньютиара | 5092744 | 2017.08.11 | 488 |
| | | | Эрдэнэдалай | | 17 141,41 | | | | | |
| 2 | XV-011946 | Дорноговь | Сайншанд | | 1 793,41 | Тодорхой хэсгийг | Кожеговь | 2078449 | 2017.08.22 | 500 |
| | | | Улаанбадрах | Зөөвч овоо | 5 425,49 | | | | | |
| 3 | XV-011921 | Дорноговь | Улаанбадрах | Дулаан | 2 955,24 | Тодорхой хэсгийг | Кожеговь | 2078449 | 2017.08.23 | 507 |
| 4 | XV-019801 | Дорнод | Хөлөнбуйр | Хэрлэн | 6 856,31 | Тодорхой хэсгийг | Эс Ар Эм | 5038111 | 2017.08.28 | 527 |
| 5 | XV-014152 | Ховд | Үенч | Загт | 5 474,72 | Тодорхой хэсгийг | Дүүлэх шонхор | 2160757 | 2017.08.31 | 534 |
| 6 | XB-020584 | Увс | Бөхмөрөн | Мөст | 44,03 | Бүхэлд нь | Хотгор | 2661128 | 2017.08.09 | 481 |

### Барьцаанд бүртгүүлсэн тусгай зөвшөөрөл

| № | Тусгай зөвшөөрлийн дугаар | Аймаг / хот | Сум / дүүрэг | Талбайн нэр | Талбайн хэмжээ (га) | Эзэмшигч | Эзэмшигчийн регистр # | Барьцаалагч | Барьцаалаг-чийн регистр | Шийдвэрийн огноо | Шийдвэр # |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | MV-016658 | Дорнод | Баян-Уул | Хужирт | 345,46 | Болоршүр | 5199174 | Монгол улсын хөгжлийн банк | 5461626 | 2017.08.31 | 535 |
| 2 | MV-020732 | Дархан-Уул | Хонгор | Хуурай-1 | 31,71 | Хааны харгуй | 4249305 | Монгол улсын хөгжлийн банк | 5461626 | 2017.09.01 | 535 |

### Нөхөн олгосон тусгай зөвшөөрөл

| Д/д | Тусгай зөвшөөрлийн хуучин дугаар | Шинэ дугаар | Аймаг | Сум | Талбайн нэр | Нийт талбайн хэмжээ | Эзэмшигч | “Эзэмшигчийн Регистрийн дугаар” | “Шийдвэрийн огноо” | “Шийдвэрийн дугаар” |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | MR-011283 | MV-020895 | Сэлэнгэ | Ерөө | Бугант-1 | 39,15 | Хишиг-Оргилуун | 5029066 | 2017.08.28 | 526 |
| 2 | MR-009256 | MV-020888 | Сэлэнгэ | Орхонтуул | Цагаан гозгор | 63,16 | Коол Адвентурс | 5244552 | 2017.08.09 | 483 |

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
КАДАСТРЫН ХЭЛТЭС**

# ОНЦЛОХ ХУУДАС

## Speak out




# БҮХИЙ Л НАСНЫ ИРГЭД СОШИАЛЫН МЭДЭЭЛЭЛД ИТГЭДЭГГҮЙ ЮМ БАЙНА

Г.ГАНЧИМЭГ

*Сошиал орчин дахь мэдээллийг л авахгүй бол, ядахдаа хоногтоо нэг шагайж байхгүй бол юунаас ч юм хоцорчих гээд ч байгаа юм шиг сонин цаг үед амьдарч байна, бид. Гэхдээ үнэндээ тийм биш юм байна. Бидэнтэй уулзсан хүмүүс бүгдээрээ л сошиалд итгэдэггүй. Харин цаасан хэвлэл, тэр дундаа өдөр тутмын сонины мэдээлэлд илүү итгэдэгээ хэллээ. Зарим нь бүр албан ёсны эх сурвалж, бариад очиход баримт болдог гэж үзэж байна.*

## Ш.Батсүх: Би өдөр тутмын сонинд итгэдэг



*/Сүхбаатар дүүргийн IV хорооны иргэн/*

-Би өдөр тутмын сонин уншиж, түүнд л итгэдэг. Одоо ч зарим нь өвөрт явж байна. Захиалж уншдаг юм. Өдөр тутмын сонины мэдээлэл арай үнэнд ойр, бодитой байдаг юм болов уу даа л гэж боддог. Харин тэр сошиал орчин дахь фэйсбүүкийн мэдээлэл ихэвчлэн худал байдаг. Тиймээс үүгээр гарсан мэдээлэлд итгээд байдаггүй. Цаг үрсэн дэмий зүйл их цацаж байна. УИХ-ын гишүүд, төрийн өндөр алба хашиж байгаа хүмүүсийн ярилцлага, байр суурь болоод төр, засгийн албан ёсны мэдээлэл ихэвчлэн өдөр тутмын сонингоор гардаг. Үүнийг л их сонирхож уншиж, албан ёсны эх сурвалжтай мэдээлэл авах дуртай.

## Ц.Содном: Цахим орчинд орохоо больсон



*/Сүхбаатар дүүргийн XVI хорооны иргэн/*

-Өдөр нь сонин уншиж, орой нь телевиз үзэж, өөрт хэрэгтэй мэдээллээ олж авдаг даа. Сонингуудаас өдөр тутмын хоёр сонинг байнга захиалж уншдаг. Мэдээлэл нь хүртээмжтэй, албан ёсны, редакци нь хариуцлагатай байж чаддаг. Харин хамгийн найдваргүй, хамгийн худал мэдээлэл фэйсбүүкээр тэнэж, сошиалаар явж байна. Тэрэн дотор чинь үнэн юм байгаа юм уу. Хүнийг гүтгэж доромжлох зэрэг нь наад захын асуудал болжээ, сошиалд. Тэгээд эргээд үзэх гэхээр байхгүй, хариуцлага тооцох эзэн биегүй. Осолгүй худал, үнэн хаяг бичдэг. Гэхдээ тэр хаяг нь хуурамч байх магадлал нь илүү. Ёстой хэрэггүй зүйл чинь тэр. Тиймээс би сүүлийн үед цахим орчинд орохоо ч больсон.

## З.Хатанбаатар: Сошиалын мэдээлэл үндэслэлгүй, худал байдаг



*/Үндэсний биеийн тамирын дээд сургуулийн оюутан/*

-Өөрт хэрэгтэй чухал мэдээллийг сониноос л олж авдаг. Уншсан зүйл маань арай үлдэцтэй, ойлгомжтой байдаг юм. Сонин дундаа өдөр тутмынх нь арай дээр, илүү өгөөжтэй, чанартай санагддаг. Одоохондоо оюутан учраас тэр болгон өөрийн сонирхсон хэвлэлээ захиалаад байж чаддаггүй. Гэхдээ ах эгч, аав ээжийнхээ захиалсан сонинг авч уншдаг. Уг нь сошиал орчинд фэйсбүүкт байнга ордог л доо. Даанч мэдээлэл нь үндэслэлгүй, хүмүүсийг баахан шууруулчихаад эргээд харах гэхээр нь устгачихдаг. Худал мэдээлэл тавьдаг болохоороо л тэр байх.

## Ц.Базаррагчаа: Фэйсбүүк хандалтаа өсгөхийн тулд хуурамч мэдээлэл тавьдаг



*/Сүхбаатар дүүргийн IX хорооны иргэн/*

-Өдөр болгон онлайн орчинд байж, фэйсбүүк, твиттерээр янз бүрийн л мэдээлэл авдаг. Гэхдээ фэйсбүүкийн мэдээлэл ихэвчлэн худал, хандалтаа өсгөхийн тулд хаа хамаагүй хуурамч мэдээлэл их тавьдаг юм билээ. Онлайн орчинд ямар ч хүнийг яаж ч алж болдог боллоо шүү дээ. Тэгээд тэрийгээ устгадаг. Тиймээс телевизүүдийн мэтгэлцээн, сонины ярилцлагын булан, байр сууриа илэрхийлсэн мэдээллүүдэд илүү итгэж уншдаг. Өдөр тутмын сонин бол албан ёсны эх сурвалжтайгаа байж л байдаг. Харин онлайн орчны мэдээллүүд худал, үнэн нь батлагдахгүй байж байгаад агаарт замхардаг.

## Н.Дамба: Цахим мэдээлэлд итгэдэггүй



*/Чингэлтэй дүүргийн VII хорооны иргэн/*

-Өөрт хэрэгтэй мэдээллээ ихэвчлэн телевизээс л авч байна даа. Орой ажил тараад арай зав чөлөөтэй болсон хойноо тухтай үзээд суудаг. Бодит хүн ярьдаг болохоор тал хувь нь үнэний ортой л байх гэж боддог. Хааяа нэг сонин гарчигладаг. Одоо ч нийгмээрээ л үнэн худал нь мэдэгдэхгүй хачин цаг үе ирж дээ. Залуучууд цахим орчноос л мэдээлэл авч байх шиг байна. Бидний насныхан хувьд түүнд итгэдэг ч үгүй. Хариуцлага хүлээх чадвартай, редакцитай, томоохон сонины нийтлэлийг уншдаг.

## М.Бодьхүү: Хүний амаар дамжуулан мэдээллээ авдаг



*/Сонгинохайрхан дүүргийн X хорооны иргэн/*

-Эмээ нь нүд муутай учраас сонин уншдаггүй. Харин зурагт л их үздэг. Ер нь сонсдог гэх үү дээ. Заримдаа хүүхдүүдээр сонин гарчиглуулна. Хүний амаар л дамжуулан өөрт хэрэгцээтэй мэдээллээ олж авч байна даа. Ажиглаад байхад, болж бүтэж байгаа юм бага л юм шив дээ гэж боддог.

## Н.Алишер: Утсаа алга болгочихоод сонин уншиж байна

*/Сүхбаатар дүүргийн XI хорооны иргэн/*



-Би ихэвчлэн интернэтээр цахим сонин үзэх дуртай. Хааяа эмээгийндээ очихоороо цаасан сонин үздэг. Аав маань эмээд өдөр болгон сонин авч өгдөг юм. Одоохондоо эмээ маань хөдөө явчихсан байгаа учраас би интернэтээр цахим сонин үзэж байгаа. Сонингийн мэдээлэл илүү үнэн бодитой байдаг. Харин фэйсбүүкээр худал мэдээлэл их явдаг юм билээ. Би утсаа алга болгочихсон учраас одоо фэйсбүүкээр ордоггүй. Сонин л уншдаг болоод байгаа.

## Э.Сайнгэрэл: Фэйсбүүкийн мэдээлэл ихэнх нь худал байдаг

*/Баянзүрх дүүргийн XIX хорооны иргэн/*



-Оройдоо зурагтын мэдээ үздэг. Ихэвчлэн фэйсбүүкээр л мэдээлэл авдаг даа. Гэхдээ фэйсбүүкээр явж байгаа мэдээллүүд худал, хандалт авахын тулд тавьсан байх нь ч бий. Албан ёсны редакцитай, томоохон сайтын мэдээллүүд үнэнд ойр, бодитой санагддаг. Харин хувь хүний хаяг дээрх мэдээллийн ихэнх нь худал байдаг шүү.

## Г.Лхамсүрэн: Сошиалыг мэдэхгүй



*/Сүхбаатар дүүргийн XI хорооны иргэн/*

-Эмээ нь Дорнод аймгийн Дашбалбар сумын хүн. Айлын ганц басган. Аав, хоёр ах маань хэлмэгдлийн үед алга болж, их зовлон үзсэн дээ. Одоо чих хатуу. Тэтгэвэр авдаггүй учраас сонин хэвлэл захиалж чаддаггүй юм. Гэхдээ айлын хүүхдүүдийн гэртээ авчирсан сонинг гуйж авч уншдаг. Өдөр тутмын сонингууд их сайхан шүү дээ. Хүнд хэрэгтэй мэдээллүүд байдаг. Түүнээс биш тэр сошиал мошиалыг чинь эмээ нь мэдэхгүй.



## Ж.Гансүх: Цахим сүлжээнээс мэдээлэл авдаггүй

*/Сүхбаатар дүүргийн XI хорооны иргэн/*

-Би байнга өдөр тутмын сонин уншдаг. Өдөр тутмын сонингуудад л бүх төрлийн мэдээлэл гарч байна. Энэ нь илүү хүртээмжтэй, үнэн бодитой санагддаг. Ихэвчлэн улс төр, эдийн засаг, дэлхий дахины байдлыг сонирхдог. Харин цахим сүлжээнээс мэдээлэл авдаггүй.

## Боко Харам бүлэглэлийн халдлагаар 400 хүн нас баржээ

Нигер, Камерун зэрэг улсад хэт даврагч Бока Харам бүлэглэлийн дайралт довтолгоон идэвхжиж, олон зуун хүн амиа алдаж буй тухай Олон улсын хүний эрхийн Эмнести Интернэйшнл байгууллага өчигдөр мэдээллээ.

Тодруулбал, энэ оны 4-8 дугаар сарын хооронд дээрх хоёр улсад хэт даврагчдын халдлагын улмаас нас барагсдын тоо өмнөх таван сард амиа алдсан иргэдийн тооноос даруй хоёр дахин их буюу 400-д хүрсэн байна. Сүүлийн үед хэт даврагч Боко Харам бүлэглэлийн террорист халдлагын давтамж нэмэгдэж, хоёр улсын хэмжээнд 381 хүн амиа алдсан байна. Тэд амиа золиослох халдлагадаа ихэвчлэн залуу бүсгүйчүүд, насанд хүрээгүй охидыг ашиглах тохиолдол ч олон гарчээ. Эмнести Интернэйшнл байгууллагын Баруун болон Төв Африкийн асуудал эрхэлсэн салбарын захирал Алиоуне Тине “Боко Харам удаа дараа томоохон хэмжээний дайны гэмт гэмт хэрэг үйлдэж байна. Мөн олон хүмүүсийг нэг дор хөнөөх зорилгоор охид эмэгтэйчүүдийн биед тэсрэх бодис бүслэн амийг нь золиослуулж байна” хэмээжээ. Эмнести Интернэйшнл байгууллагаас мэдээлснээр, Зөвхөн Нигерт гэхэд Боко Харам бүлэглэлийн үйлдсэн террорист халдлагаар өнгөрсөн дөрөвдүгээр сараас хойш багадаа 223 энгийн иргэн амиа алдсан байна. Гэхдээ бүртгэгдсэн тоо нь л энэ болохоос биш, бодит байдалд үүнээс ч илүү хүн нас барсан байх магадлалтай аж. 2009 оноос хойш Нигер дэх хохирогчдын тоо 20 мянгыг давж, 2.6 сая хүн орон гэрээ орхин ойролцоох улс руу дүрвэсэн гэсэн тоон баримт байгаа юм.

## Лос-Анжелест онц байдал тогтоолоо

АНУ-ын баруун этгээд дэх Калифорни мужийн Лос-Анжелес хотын нутаг дэвсгэрт томоохон хэмжээний хээрийн түймэр гарч, 2800 га талбай шатжээ. Үүний улмаас орон нутаг даяар онц байдал зарлаж, 1000 гаруй гал сөнөөгчид түймрийн голомтод ажиллаж байна. Түймэр энэ сарын 1-нд Лос-Анжелес хотын зах хэсэгт гарчээ. Гэвч, ойрын өдрүүдэд тухайн бүсэд бүгчим халуун үргэлжилж, салхи хүчтэй салхилсны улмаас түймэр илүү өргөн зайд тархсан байна.

Хэдийгээр галын тархалтыг эдүгээ зогсоож чадсан ч, өнөөг хүртэл дөрвөн оршин суугч түлэгдсэнээс гадна 700 гаруй хэсгийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх шийдвэр гаргажээ. Мөн түймэртэй холбогдуулан Лос-Анжелес хот энэ сарын 2-нд онц байдал зарлаж, онцгой байдлын 1000 гаруй алба хаагчдыг түймэн унтраахад дайчилсан байна. Тэдний дунд Харви хар салхинд өртсөн Техас мужид ажиллаж байсан 100 орчим аврагчдыг яаралтай дуудаж, түймэр унтраалгахаар ажиллуулж эхэлсэн гэх мэдээлэл байгаа юм. Лос-Анжелест гал түймэр гарахаас хоёр долоо хоногийн өмнөөс бүгчим халуун үргэлжилж, түүхэнд байгаагүй халуун буюу 42 градус хүртлээ халж байжээ.

АНУ-ын баруун хэсэгт өнгөрсөн сард ч гэсэн Калифорни мужийн аялал жуулчлалын газрууд болон цэцэрлэгт хүрээлэнгийн ойролцоо түймэр гарч, 4000 гаруй хүнийг аюулгүй газар нүүлгэн шилжүүлэх шаардлагатай болсон байна.

# ХОЙД СОЛОНГОСЫН АСУУДЛААР ЯПОН МОНГОЛТОЙ ТОХИРОЛЦОХ УУ




Б.ДАВАА

Японы Либериал ардчилсан намын гишүүн, Япон Монголын найрамдлын бүлгийн дарга М.Хаяаши, Коомэй намын парламентын гишүүд өнөөдөр манай улсад айлчлах тухай NHK мэдээлжээ. Айлчлалын үеэр төлөөлөгчид Ерөнхийлөгч Х.Баттулгатай уулзаж, хэд хэдэн удаа цөмийн зэвсэг туршиж, баллистик пуужин харваж буй Хойд Солонгос улсад үзүүлэх бодит дарамт шахалтыг чангатгахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр ярилцахаар төлөвлөж байгаа юм байна.

Япон Монголын найрамдлын бүлгийн даргаар эдүгээ ажиллаж буй Либериал намын Ерөнхий нарийн бичгийн дарга М.Хаяаши болон Либериал, Коомэй намын парламентын дээд танхимын гишүүд гээд нийт таван төлөөлөгч өнөөдөр манай улсад ирж, дөрвөн өдрийн хугацаатай ажиллах гэнэ.

Айлчлалын үеэр Ерөнхийлөгч Х.Баттулга, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат нарын удирдлагуудтай уулзаж, дээрх чиглэлээр санал солилцохоор төлөвлөсөн байна. Гэхдээ орон нутгийн мэдээллийн сайтуудад бичсэнээр дээрх уулзалтын үеэр М.Хаяаши нарын гишүүд Хойд Солонгосын хэрэгжүүлж буй цөмийн зэвсэг, баллистик пуужингийн туршилт нь Японы аюулгүй байдал, энх тайванд томоохон заналхийлэл учруулж буйг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэдгийг онцлохын зэрэгцээ асуудлыг зөвхөн ярилцаад өнгөрөх бус, бодит дарамт шахалт үзүүлэх шаардлагатай байгааг уриалах ажээ. Ингэхдээ НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс тус улсын эсрэг дахин шинэ хориг арга хэмжээ авах шаардлагатай байгааг уриалах юм байна.

Үүний зэрэгцээ, шинэ хориг арга хэмжээ авахдаа ямар нэг цоорхой үүсгэхгүйгээр, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн шийдвэрийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхүйц байхаар төлөвлөж, Хойд Солонгос улстай дипломат харилцаатай Монгол Улсад хамтарч ажиллахыг санал болгох байр суурьтай байгаа гэнэ.

Энэ удаагийн уулзалт нь Япон, Монгол хоёр улс дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойтой давхцаж буйгаараа онцлог. Тиймээс уулзалтаар хоёр улсын харилцааг нэг шатаар ахиулах, худалдаа хөрөнгө оруулалтаа өргөжүүлэх зэрэг асуудлаар санал бодлоо солилцох юм байна.

Олон улсын тавцанд хэдхэн улстай дипломат харилцаатай хэвээр байгаа Хойд Солонгос улс энэ сарын 3-нд зургаа дахь удаагийн цөмийн зэвсгээ туршсан билээ. Пхеньяны зүгээс асар их хор хөнөөл бүхий устөрөгчийн бөмбөг туршсан гэж мэдэгдсэн байдаг. Гэвч, энэ үйл явдал нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс тус улсын эсрэг шинэ хориг арга хэмжээ авснаас хойш болсон юм.

Тиймээс Хойд Солонгосын заналхийллээс хамгийн их хохирол амсах магадлалтай Японы төлөөлөгчид Пхеньянтай холбоо харилцаатай орщдог манай улсыг Солонгосын хойгийн харилцааг зохицуулж чадахуйц чухал түнш гэж үзэн энэ өдрүүдэд айлчлахаар зэхэж байгаа бололтой. Манай улсын Засгийн газрын хувьд Хойд Солонгосын аюултай нүүдлийг буруутгаж байгаа ч, Улаанбаатар Солонгосын хойг дахь эдийн засаг, улс төр, иргэний асуудлыг тогтворжуулах дипломат бодлого, эдийн засгийн арга замыг хайсаар байгаа билээ. Ямартай ч, Японы төлөөлөгчидтэй хийх уулзалтаар талууд ямар чиглэлээр тохиролцоонд хүрэх нь олон улсын анхаарлыг татаж байна.


# САНАЛЫН УРИЛГА

Ашигт малтмал, газрын тосны газар нь Ашигт малтмалын тухай хууль болон, Засгийн газрын 2017 оны 37 дугаар тогтоол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/129 дүгээр тушаалаар батлагдсан “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.6-т “Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор орон нутгийн тусгай хэрэгцээний газартай давхцалтай эсхүл хууль бус олборлолтонд өртсөн талбайтай сонгон шалгаруулалтын талбай нь давхцаж байвал тухайн орон нутагт үүсгэн байгуулагдсан орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн дунд хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох сонгон шалгаруулалтыг хязгаарлагдмал байдлаар зохион явуулж болно” гэж заасныг тус тус үндэслэн дараах талбайд ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авах хязгаарлагдмал сонгон шалгаруулалтад оролцох аж ахуйн нэгжүүдийг санал ирүүлэхийг урьж байна.

Сонгон шалгаруулалт зарлах талбайн босго үнэ болон бусад мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газрын цахим хуудсанаас (www.mrpam.gov.mn) авна уу. Мөн Ашигт малтмал, газрын тосны газраас авч болно.

1. “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын 5.2-д заасан үйлчилгээний хөлс төлж Сонгон шалгаруулалтын талбайн товч мэдээллийг авна уу.
2. Сонгон шалгаруулалтад оролцох саналыг 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 17 цаг хүртэлх хугацаанд Ашигт малтмал, газрын тосны газрын 309 тоот өрөөнд Сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн даргад оролцогч аж ахуй нэгж, байгууллагын захирал, дарга эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч биечилэн хүлээлгэн өгнө.
3. Сонгон шалгаруулалтад оролцох саналыг сонгон шалгаруулалтанд оролцогч аж ахуйн нэгжийн захирал эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг байлцуулан 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 30 минутад Ашигт малтмал, газрын тосны газрын хурлын танхимд нээнэ. Аж ахуйн нэгжийн захирал эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь тогтоосон хугацаанд ирээгүй бол саналыг задлахгүйгээр хүчингүйд тооцож буцаан хүлээлгэн өгнө.
4. Ирүүлсэн саналыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаалаар батлагдсан коммисс Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/129 дугаар тушаалаар батлагдсан “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын дагуу үнэлнэ.
5. Сонгон шалгаруулалтад оролцох санал ирүүлэх хаяг:

Засгийн газрын 12 дугаар байр, Барилгачдын талбай-3, Ашигт малтмал, газрын тосны газар 309 тоот өрөө, Сонгон шалгаруулалт явуулах комиссын нарийн бичгийн дарга
утас 263704
Саналд дараах бичиг баримтыг хавсарган ирүүлнэ.

Үүнд:
- Сонгон шалгаруултанд оролцох тухай албан бичиг
- Санал гаргагчийн албан ёсны тодорхойлолт (маягт К-4)
- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (нотариатаар баталгаажуулсан)
- Монгол Улсад татвар төлөгч болох тухай нотолгоо (харьяа татварын албанаас)
- Сонгон шалгаруулалтын босго үнийг Монгол Банкинд бүртгэлтэй арилжааны банкинд хугацаатай / Сонгон шалгаруулалтын саналыг нээсэн өдрөөс хойш ажлын 15 хоног/ байршуулсан баталгаа
- Сонгон шалгаруулалтанд оролцох битүүмжлэгдсэн үнийн санал (босго үнэ + санал үнэ = нийт үнэ)
- Тухайн талбайд гүйцэтгэх хайгуул болон ашиглалтын ажлын төрөл хэмжээ, хугацаа, өртөг болон байгаль хамгаалахад зарцуулах зардлыг тоймлон тусгасан төсөл, төсвийн санал
- Хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулах техник, тоног төхөөрөмжийн жагсаалт (баримтыг наториатаар гэрчлүүлсэн байна)
- Мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн ажилтнаар хангагдсан байдал. (баримтыг наториатаар гэрчлүүлсэн байна)
- Хайгуул, ашиглалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг явуулах, дэвшилтэт арга, аргачлал, технологийн шийдэл;
- Орон нутагтай хамтран ажиллах тухай шийдэл
- Ашигт малтматын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу хийгдсэн талбайн зураг. / Кадастрын хэлтсээс авах /
- “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын 5.2-д заасан үйлчилгээний хөлс төлсөн баримт
 (төлбөрийн баримтын эх хувь)
- Сонгон шалгаруулалтанд оролцогчийн Монгол Улсад байнга байрших албан ёсны шуудангийн хаяг, Сонгон шалгаруулалтад оролцогчийн хаяг нь дээр дурдсан журмын 5.8-д заасан хаягтай адил байна.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР


## Монгол Улс өгөөмрөөрөө 29-т жагсчээ

Их Британийн “Charities Aid Formation” буяны байгууллага улс орнуудыг хэр өгөөмрөөр нь жагсаасан “World Giving Index 2017” тайлангаа даваа гарагт танилцуулжээ. Дэлхийн нийт хүн амын 95 хувийн төлөөлөл болсон 139 улс орныг хамруулсан уг жагсаалтад Монгол Улс 29 дүгээр байрт бичигдсэн байна. Энэ нь өнгөрсөн оныхоос хоёр байраар ухарсан үзүүлэлт аж. Ард түмэн нь буяны байгууллагад хэр хандив өгдөг, сайн дурын ажилд хэр идэвхтэй оролцдог болон зовж зүдэрсэн танихгүй хүнд тусалдаг эсэх гэсэн гурван шалгуураар улс орнуудыг жагсаасан байна. Энэхүү жагсаалтыг Мьянмар улс дөрвөн жил дараалан тэргүүлжээ. Зүүн Өмнөд Азийн энэ улсад судалгаанд хамрагдсан 10 хүн тутмын ес нь “Буяны үйлсэд идэвхтэй оролцдог” гэж хариулжээ. Жагсаалтын хоёр болон гуравдугаар байрт Индонез болон Кени улс бичигдсэн байна. Харин жагсаалтын 139 дүгээр байрт дайны хөлд нэрвэгдээд буй Йемен улс оржээ. “Charities Aid Formation” байгууллагын мэдэгдсэнээр, 2017 онд дэлхийн хэмжээнд өглөг өгөх нь ерөнхийдөө багассан болович хамгийн ядуу тив болох Африкийн улс орнуудын ард иргэд өглөг өгч, сайн үйлсийн ажилд оролцох нь эрс нэмэгджээ.


# АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.6, 34.7 дахь хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн хамт төлөөгүй, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн дараах аж ахуйн нэгжийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2017 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 540 дүгээр шийдвэрээр цуцалсныг мэдэгдэж байна.

| № | Тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар | Анх олгосон огноо | Аймаг, хот | Сум, дүүрэг | Талбайн нэр | Аж ахуйн нэгжийн нэр |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | XV-018457 | 2015.07.02 | Увс | Тариалан | Орлог | Ньюкомерс ХХК |
| 2 | XV-018571 | 2015.07.02 | Увс | Түргэн | Шунхат | Шунхатбаян ХХК |
| 3 | XV-017803 | 2015.07.03 | Өмнөговь | Баяндалай | Бүр толгой | Ланд-Оре ХХК |
| 4 | XV-018508 | 2015.07.08 | Увс | Өндөрхангай | Дунд | Кей Би Жи Эс ХХК |
| 5 | XV-018808 | 2015.07.10 | Увс | Өндөрхангай, Цагаанхайрхан | Хөндий-2 | Геоталст ХХК |
| 6 | MV-017043 | 2012.05.25 | Өмнөговь | Ноён | Товон уул-1 | Эс Эс Жи Пи ХХК |
| 7 | XV-020222 | 2016.05.11 | Хэнтий | Цэнхэрмандал | Их зүүн | Авад ресурс ХХК |
| 8 | XV-018901 | 2015.07.20 | Увс | Тариалан, Түргэн | Улаан | Төгөлдөр майнинг ХХК |
| 9 | MV-012549 | 2007.07.17 | Сэлэнгэ | Сайхан | Сайхан-3 | Дарханшар бүрд ХХК |
| 10 | XV-018534 | 2015.06.16 | Увс | Наранбулаг | Горхи | Юү И Ар Ти Си Эф Жи ХХК |

АМГТГ-ЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

НИЙГЭМ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

*Дархан-Уул аймгийн ДСЦТС ХК-ийн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Батжаргалтай цаг үеийн асуудлаар ярилцлаа.*

**-“ДСЦТС” ХК анх хувьчлагдаж байсан тэр үеэтэй харьцуулахад үйл ажиллагааны цар хүрээ, бүтэц орон тоо хэрхэн өөрчлөгдөв?**

-Манай компани үүсгэн байгуулагдаад52жилболжбайна. Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Эрчим хүчний тухай хуулийн дагуу Засгийн газрын 2001 оны наймдугаар сарын 01-ны 164 дүгээр тогтоол, ТӨХ-ны 454 дүгээр тогтоолоор зарласан нээлттэй уралдаант шалгаруулалтаар хувьчлагдан “Дархан Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээ” ХК нь 2004 онд “Хасвуу” ХХК-ийн мэдэлд шилжин үйл ажиллагаагаа явуулж байгаа. Мөнгөний ханш ч чанга байх тэр үед 3.6 тэрбум орчим төгрөгөөр хувьчлагдсан юм. Тухайн үед би Борлуулалтын асуудал эрхэлсэн дэд захирлаар ажиллаж байхдаа Жаргалант Зүүнхараагийн салбарыг хувийн хэвшилд шилжүүлэх комисст орж ажилласан. Тэргүүн дэд захирал Ганхуяг хойд чиглэлд, гүйцэтгэх захирал Цэрэндамба манай төвийн хэсэгт гээд бид гурав гурван тийшээ явж хувийн хэвшилд шилжүүлэн өгч байсан түүхтэй. Ингэж л манай компани салбартаа анхдагч хувийн цахилгаан түгээх сүлжээ болсон доо. Тухайн үед техник тоноглолууд их муудсан, санхүү эдийн засаг ч хүнд байлаа. Гэхдээ яваандаа зорилго нь тодорхой болоод, хөрөнгө мөнгөний асуудал шийдэгдээд ажил аяндаа жигдэрч эхэлсэн. Анх хувьчлагдахдаа манай компани 372 ажилтантай байсан. Үйл ажиллагаагаа өргөжүүлж, техник технологио сайжруулж, өнөөдрийн байдлаар 434 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. Бид техник технологийн хувьд дэвшиж, сайжирсаар байгаа. Нийтдээ 11 систем, програм хангамжуудыг нэвтрүүлж чадлаа. Бид ажиллагсдынхаа нийгмийн асуудалд жилдээ 400 сая төгрөг зарцуулж үйлдвэрчний хороотойгоо хамтын гэрээ байгуулан ажиллаж, ажилчдынхаа цалин хөлсийг ч гэсэн ЭХЗХ-оос тогтоож өгсөн тарифын хэмжээнд нэмсээр ирсэн.

Одоо ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхээр ажилчиддаа зориулсан орон сууцны барилга барьж эхлээд байна. Манай нийт ажилчдын 60 гаруй хувь нь залуучууд байгаа. Тиймээс тэднийг сургах, мэргэшүүлэх, орон байртай болгох тал дээр анхаарч ажиллаж байна.

**-Үйлчлэх хүрээний хувьд ямар байна. Цаашид өргөжих үү?**

-Сэлэнгэ аймгийн Баруунбүрэнгээс бусад бүх сумд ордог. Дархан-Уул аймгийн бүх сумд, Төв аймгийн хойд хэсгийн зургаан сум ордог. Төв аймгийн Заамар, Борнуураас хойш нийт 73 мянган км квадрат газар ажил үйлчилгээгээ хүргэн ажиллаж байна. Энэ үйлчлэх хүрээнд 50 гаруй жил ажиллаж байна. Цаашид өөрчлөгдөхгүй байх.

**-Жил ирэх тусам цахилгаан эрчим хүч хэрэглэгчийн тоо өсөж байна. Өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хэрхэн хангаж ажиллаж байна вэ?**

-Компанийн хэмжээнд нийт 47 мянга гаруй хэрэглэгчтэй. Жил бүр 2000 айл өрхөөр нэмэгдэж байдаг. Харамсалтай нь сүүлийн үед зарим уул уурхай, барилгын материалын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд ороод байна. Дархан-Уул аймгийн хэмжээнд шинээр баригдаж байгаа орон сууц, газар олголттой холбоотойгоор жилдээ 1000 гаруй хэрэглэгчээр нэмэгдэж байна.

**-Хэрэглээг хангах дэд бүтцээ компанийн хөрөнгөөр байгуулж байна уу?**

-Бидэнд 2015 он хүртэл тийм боломж байгаагүй. Байнга л улсын төсвөөр хийлгэе гэдэг саналыг аймаг, сум руу өгдөг байсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013-2015 онд 20.8 тэрбум төгрөгийн өртөгтэй томоохон ажлууд хийгдсэн. Нэг үеэ бодоход Дархан-Уул аймагт шинэ хэрэглэгч холбогдоход айх зүйлгүй болсон. II хороолол, 11-31 дүгээр хороолол, Хөтөл хорооллын цахилгаан хангамжийн асуудлыг шийдчихлээ. Өнөөдрийн байдлаар Дарханд цахилгаанд холбогдоогүй нэг ч айл байхгүй. Аймгийн Засаг даргын уулзалт болон сонгуулийн үеэрх уулзалтууд, байгууллагаас зохион байгуулдаг хэрэглэгчдийн өдөрлөгийн үеэр цахилгаанд холбогдоогүй айл өрхүүд мэр сэр гарч ирдэг. Ийм асуудлыг тухай бүр нь шийдвэрлэж байгаа. 2016 оны сонгуулиар 170-аад айл гарч ирснийг нь тухайн ондоо багтааж холбож өгсөн. Саяхан 1-3 дугаар багт зохион байгуулсан Иргэний танхимын хэлэлцүүлгийн үеэр долоон айл гарч ирснийг бас цахилгаантай болголоо. Ер нь бол бичиг баримтаа бүрэн бүрдүүлж, газрын гэрчилгээгээ авсан зөвшөөрөлтэй айл өрхийг цахилгаанаар хангах бодлого баримталжбайна. Зөвшөөрөлгүй, төлөвлөлтөд багтаагүй газар буусан айлуудыг цахилгаанаар хангахыг орон нутгийн засаг захиргаанаас хориглосон байдаг. Иргэдийн тавьсан хүсэлтийн дагуу энэ жил тэрбум орчим төгрөгөөр Ширээ нурууны модон шугамтай, бие биеэсээ дамжуулаад авсан цахилгаантай айлуудыг бетонон тулгууртай, агаарын кабель шугамтай, ухаалаг тоолууртай болгох ажил хийгдэж дуусч байна.




# Б.БАТЖАРГАЛ:
# ДЭД СТАНЦУУДЫН ХҮЧИН ЧАДАЛ ДАРААГИЙН 10 ЖИЛДЭЭ АСУУДАЛГҮЙ БОЛСОН

**-Бетонт тулгуураа танайх өөрсдөө үйлдвэрлэдэг үү?**

-Тийм ээ. Бетонт тулгуурыг манайх үйлдвэрлэдэг болоод хоёр жил болж байна. Төмөр хийцүүдээ өөрсдөө хийж байна. Төмөр, тоолуурын хайрцагнаас бусад тоноглол сэлбэг материалаа ОХУ болон Германаас авдаг. Энэ нь чанартай, үйлдвэрээс шууд авдаг тул өртөг боломжийн.

**-Сүүлийн үед хийгдсэн томоохон хөрөнгө оруулалтын ажлуудаас нэрлэвэл?**

-2015 онд зургаа гаруй тэрбум, 2016 онд 7.2 тэрбум төгрөгийн ажил хийсэн. 2017 онд 9.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хийхээр төлөвлөн ажилдаа ороод байна . Бүс нутгийн хэмжээнд хийж байгаа ажлуудаас Ухаалаг тоолуур, Европ стандартын нарийн технологитой, өндөр өртөгтэй ажлууд нь Дарханд хийгдэж байсан бол одоо бүх салбарууд руу нэвтэрлээ. Анх ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэх ажил руу бид ямар ч туршлагагүй онолын мэдлэгтэй залуусаас ажлын хэсэг байгуулаад 2012 онд орж байсан. Манай оронд байтугай ОХУ-д ч нэвтрээгүй. Хятадад дөнгөж шинээр эхэлж байсан гээд бод доо. Эхний үед хүнд байсан ч хагас жилийн хугацаанд учраа олж, программ хангамжуудаасаа эхлэх нь зүйтэй юм байна гэж үзсэн. 2012 онд Дарханы Тосгон хэсэгт программ хангамжуудаа өөрчилж эхэлсэн. Энэ маань амжилттай болсон учир хуучин 1961 онд баригдсан Төмөр замын холбооны байшинг буулгаж, 2013 онд Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн барилгыг барьж, бүтэц зохион байгуулалтаас эхлээд бүх зүйлийг өөрчилсөн. Мөн л эхний жилдээ үйл ажиллагаагаа тогтвортой сайн явагдаагүй, ажлын үзүүлэлтүүд нь муудаж эхэлсэн. М.Навчаа даргатай ХҮТ-ийн хамт олоны уйгагүй хичээл зүтгэлээр ухаалаг тоолуурын систем жигдэрч амжилттай болон бусад салбарууд руу нэвтэрсэн хэрэг. Өнөөдрийн байдлаар нийт хэрэглэгчдийнхээ тал хувийг буюу 23 мянган хэрэглэгчийг ухаалаг тоолуурт шилжүүлсэн. 2017 оны хоёрдугаар хагас жилд дахиад 23 мянгыг тавьчих юм бол “ДСЦТС” ХК тэр чигээрээ ухаалаг тоолуурт шилжинэ гэсэн үг. Урьд нь айлуудад цаас бичээд л явдаг байсан бол одоо гар утас руу нь мессэжээр явуулаад хуулийн хугацаа нь болонгуут автоматаар цахилгаанаа түдгэлзүүлээд төлбөр хийнгүүт автоматаар залгадаг гээд хүний хөдөлмөрийг хөнгөвчилж өгсөн. Нөгөө талаасаа хэрэглэгчдэд ашигтай. Хангагч хэрэглэгчийн хооронд үл ойлголцол гарахгүй их амар болсон. Энэ тоолуур нь цагийн ялгавартай тарифтай, шөнийн хямдралтай тоолдог, гэр хорооллын айлд бүр ашигтай шөнийн тарифыг дахиад 50 хувь хөнгөлнө.

**-Өдөр шөнийн тарифыг яаж тооцож байгаа билээ?**

-Өдрийн тариф өглөөний 06:00 цагаас оройны 21:00 цаг хүртэл энгийн, 21:00 цагаас 06:00 цаг хүртэл шөнийн тарифаар хямдарч байгаа. Гэтэл одоо гэр хорооллын айл өрхүүдэд шөнийн тарифыг ЭХЗХорооны тогтоолоор дахиад 50 хувь хямдруулж байна. Ингэснээр гэр хорооллын айлууд шөнөөр нүүрс түлэхгүй цахилгаанаар халаах боломжтой болж байгаа юм.

**-Нийслэл хотод хэрэгжүүлсэн шөнийн тарифыг тэглэх ажлыг Дарханд хэрэгжүүлэх боломжтой юу?**

-Иргэд аймаг сумын ИТХ, нутгийн захиргааны байгууллагуудаараа дамжуулж манай салбарын зохицуулах хороонд саналаа өгвөл үнэ тэглэдэггүй юм гэхэд хямдруулж болох байх. Хойшоо гаргаж байгаа эрчим хүчээ өртгөөр нь шөнө тооцдог болчихвол нүүрс түлдэг айлууд цахилгаан бойлуур луу шилжчихэж байгаа юм. Дарханы хувьд шугам сүлжээ нь дөнгөж шинэчлэгдээд явж байгаа учраас тийм шийдвэр гарах юм бол бид ч бас шугам сүлжээгээ нөөцтэй байгуулж байрлуулах боломжтой. Шугам тоноглолдоо шинэчлэлт хийж байгаа энэ үед айлуудын ахуйн хэрэглээнээс гадна нэмэлт халаалт бойлуур орж ирэх юм байна гэж тооцож шугам сүлжээгээ өргөтгөх ёстой юм.

> ...Хойшоо гаргаж байгаа эрчим хүчээ өртгөөр нь шөнө тооцдог болчихвол нүүрс түлдэг айлууд цахилгаан бойлуур луу шилжчихэж байгаа юм. Дарханы хувьд шугам сүлжээ нь дөнгөж шинэчлэгдээд явж байгаа учраас тийм шийдвэр гарах юм бол бид ч бас шугам сүлжээгээ нөөцтэй байгуулж байрлуулах боломжтой...

**-Одоогийн байдлаар дэд станцуудын хүчин чадал ямар байна вэ?**

-Дэд станцын хүчин чадал дараагийн 10 жилдээ асуудалгүй гэж тооцож байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 35/6 кВ-ын дэд станцыг үйлдвэрийн районд байгуулсан. Дөрвөн том хуваарилах байгууламж баригдчихлаа. Дархан хотын хувьд дараагийн 10 жилдээ цахилгаан эрчим хүчний эх үүсвэр талаасаа ямар ч асуудалгүй. Шинээр хорооллууд, барилга байгууламж баригдаад эхэлвэл цахилгаанаар хангахад асуудалгүй. Мөн хөдөөнийхөө станцуудыг шинэчилж хүчин чадлыг нь нэмэгдүүлчихсэн. Жишээлбэл, хоёр шинэ дэд станцыг Германы технологиор 2016 онд барьсан.

**-2017 оны хөрөнгө оруулалтын ажлаасаа тодруулахгүй юу?**

-2017 онд 9.2 тэрбумын хөрөнгө оруулалт хийгдэхээс гурван тэрбум орчим нь ухаалаг тоолуур худалдан авахад зарцуулагдах юм. Энэ онд манай компани мэдээллийн технологид шилжиж орсны таван жилийн ой тохиож байгаа. Ойгоо угтаад компанийнхаа бүх хэрэглэгчийг ухаалаг тоолуураар хангахыг зорьж байна. Цахилгаан эрчим хүчний хяналт удирдлага, арилжааны автоматжуулсан систем нь дотроо их том цогц 11 систем, программ хангамжаас бүрддэг бөгөөд ухаалаг тоолуурын систем нь үүний зөвхөн нэг хэсэг нь шүү дээ. Бусад нь камер, диспетчерийн хяналтын, автомашинуудын хяналтын GPS-тэй систем гээд байгаа.

**-Орон нутагтайгаа хэр уялдаж хамтарч ажиллаж байна. Дэмжлэг хэр байна вэ?**

-Маш сайн хамтарч ажилладаг. Сүүлийн 3-4 жилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар томоохон бүтээн байгуулалтууд хийгдсэн. Хөтөл хороолол, хоёрдугаар хороолол, 35/10 кВ-ын дэд станц, 11-31 дүгээр хороолол гээд таван багц бүтээн байгуулалт байгаа. Энэ ажлуудыг Улсын төсөвт суулгах, эхлүүлж хийлгэх тал дээр аймгийн талаас их санаачлагатай оролцсон.

**-Компани орлого ашгийн хувьд ямар байна?**

-Манай компани 2015 оноос хойш алдагдалгүй ажиллаж байна. Үнэ тарифыг индексжүүлсэн нь салбарын болон манай компанийн санхүү эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлж алдагдалгүй ажиллах боломжид хүргэсэн.

**-Одоо эрчим хүчний үнэ тарифт өөрчлөлт орох болов уу?**

-Өөрчлөгдөнө. Эрчим хүчний тухай хууль шинэчлэгдсэн байгаа. Энд үнийг индексжүүлнэ гэж заасан. Хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээний ажилд хэрэглэгдэх импортоор авч байгаа сэлбэг материалын үнийн өсөлтөөс зэрэг олон зүйлээс хамаарна.

**-Сүүлийн үед эрчим хүчний хэмнэлтийн горим гэж ярих боллоо. Энэ яг юуг хэлээд байна вэ?**

-Монгол Улс өөрсдөө эрчим хүч үйлдвэрлэж байгаа ч гаднаас өндөр үнээр эрчим хүч худалдаж авдаг улс. Жилээс жилд эрчим хүчний хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа. Энэ хэрэгцээгээ дотооддоо үйлдвэрлэхийн тулд бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлуудыг шат дараатай хийж байна. Гэхдээ эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үйлдвэрлэсэн эрчим хүчээ хэмнэж, дотоод нөөц бололцоогоо ашиглах зайлшгүй шаардлагатулгарсан. Энэүүднээс эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль гаргалаа. Байгууллагууд эрчим хүчний хэмнэлтийн менежерийн орон тоотой болсон. Эхний ээлжинд эрчим хүчний салбар дотор хэмнэлт явагдах ёстой. Цаашлаад нийгмийн хариуцлагатай том хэрэглэгчиддээ шаардлага тавих буюу тоног төхөөрөмжөө шинэ технологид шилжүүлэхийг санал болгох цахилгаанаа хэмнэхийг зөвлөнө.

**-Бусад орнуудын цахилгаан түгээх сүлжээний компаниудтай харьцуулахад хаана нь явж байна. Гадаад харилцаагаа хэрхэн өргөжүүлж байна вэ?**

-Манай компани Европ стандарт хэрэгжүүлэхийн төлөө л зүтгэж байна. Хятадаас төмөр хийцээс өөр тоног төхөөрөмж худалдаж авдаггүй. ОХУ болон ХБНГУ-аас тоног төхөөрөмжөө авдаг. Яагаад тийшээ зүтгээд байгаа юм гэхээр бусад хөгжилтэй орнуудаас хол хоцорсон байна. Жишээлбэл, манай компанийн 2010 оноос хойш хийгээд байгаа шугам тоноглолын шинэчлэлийн ажлыг тэд 20 жилийн хугацаанд шат дараатайгаар хийгээд дууссан байна. СКАДА болон бусад мэдээллийн шинэ технологийг нэтрүүлээд олон жилийн баялаг туршлагатай болсон. Ялангуяа үйлчилгээний тал дээр манайх их хоцрогдсон байгаа. Бид богино хугацаанд шугам сүлжээгээ шинэчлэж авахгүй бол маш их хоцрох гээд байна.

**-Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд маш олон ажлууд хийгддэг. Томоохон ямар ажлуудыг хийж ирэв?**

-Бид олон жилийн өмнөөс нийгмийн хариуцлагатай байгууллага гэгдэж хамт олон маань энэ нэр томъёог ухамсарлаж яваа. 300 мянган хүн амд үйлчилж байгаа тэднийг дулаан цахилгаантай байлгах үүрэг хүлээсэн, хэрэглэгч хаан байх ёстой гэсэн зарчмыг баримталдаг байгууллага. Өнгөрсөн онуудад манай аймагт болон Төв аймаг, Хөтөлд гарсан гамшиг ослын үеэр Онцгой байдлын газартай хамтран маш үр дүнтэй ажилласан. Ер нь нийгмийн хариуцлагын хүрээнд Дархан, Сэлэнгэ Төв аймаг гээд л бүхий л газраас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд манай салбаруудын хамт олон оролцож, дэмжлэг хүссэн тохиолдолд чадлаараа л тусалж дэмжиж ирсэн дээ.

ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

Эрхэмбаяр овогтой Ариунтунгалагийн эзэмших эрхийн 306794 гэрчилгээний дугаартай 1591м2 талбайтай 5-р багц байрлалтай газрын гэрчилгээ гээгдүүлсэн тул хүчингүй Утас 99497111

# ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр +17
Шөнө +6

Нөгөөдөр

Өдөр +22
Шөнө +6

## Өдрийн зурхай

**НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ УЛААН БИЧ ӨДӨР**

**Үс засуулбал:** *Өлзийтэй сайн.*

**Наран ургах, шингэх:** *06.22-19.23*



Аргын тооллын 9 сарын 6, Буд гараг. Билгийн тооллын 15, Шувуун хушуут одтой, улаан бич өдөр. Өдрийн наран 6 цаг 22 минутад мандан, 19 цаг 23 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сүм дуганыг сэргээх, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, хур оруулах, дарханы үйлд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

Books
“Ном” буланд тавтай морил

# ИХ ГЭРИЙН ЭЗЭГТЭЙ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь №149 дугаарт**

Дээгүүр нь шувууны далавч сэрчигнэх чимээ сонсоод дэлт бүргэдүүд үхэхийг нь тэвчээртэй хүлээж байгааг мэдлээ. Ухаан нь балартан орон гаран болжээ. Абердины сэрүүн сүмд ах нарынхаа хооронд гоёлын хувцастай сууж байх юм. Мэри эгч нь Зини Кордтой хамт зуны сайхан палааж өмссөн байна. Энни Корд өөдөөс нь хараад инээмсэглэхэд Жем босож дэргэд нь очих гэтэл хоёр ах нь бөөр лүү нь өшиглөөд байх юм. Хамаг бие нь тэсхийн аргагүй шархиран өвдөж, Жеми дахиад л эзгүй цөлд хэвтэж байх юм. Чармай нүцгэн, хугархай хөлтэй.

Дэлт бүргэдүүд тэсэж ядсан байдалтай чанга чанга дуугарч байлаа.

Тэр махчин шувуудын хаана байгааг харах санаатай нүдээ өчүүхэн төдий ч атугай нээхийг оролдов. Мэнэрсэн зовхинд нь ямар нэгэн юмсын дүрс үзэгдэх шиг болж, тэр цөөвөр чоно, нохой болж хувирав.

Салхины дээд талаас өмхий халуун үнэртэж байлаа. Зогсохтой нь зэрэг махчин амьтад дайран орж ирнэ гэж мэдэж байсан учир эцсийн хүчээ шавхан мөлхсөөр байлаа. Өвдөхийн дээр наран хайр найргүй шарж, хамаг бие нь халуу оргино... Ван Дер Мервегээс өшөө авахаас нааш бууж өгч болохгүй. Жеми орон цагийн баримжаа алджээ. Нэг миль мөлхсөн болов уу гэж өөрөө бодож байлаа. Үнэн хэрэг дээрээ хэдхэн ярд газар тойрон мөлхсөн байлаа.

Эргэн тойронюу ч харагдсангүй. Ганцхан Ван Дер Мерве дээр л хамаг анхаарлаа төвлөрүүлнэ.

Ухаан нь балартаж эхэлснээ тэсэхүеэ бэрх өвдөхөд дороо сэхэв. Хэн нэг хүн хөлийг нь огтолж байх шиг...

Жеми хаана байгаа, өөрт нь ямар явдал тохиолдсоныг тэр даруй санасангүй. Асар их хүчлэн байж нүдээ нээлээ. Лут том дэлт бүргэд хөлийг нь тоншин зулгааж байлаа. Жеми тэр махчин шувууны хар нүд, муухай өд сөдийг харлаа. Дэлт бүргэд дээр нь ирж суухад өмхий муухай үнэр нь мэдэгдэж байв. Хашгирах гэтэл дуу гарсангүй. Урагшаа нэг таталдан огзгосхийж хөлөөс нь цус гоожиж байсныг мэдэрлээ. Махчин шувууд дээгүүр нь эргэлдэн юу юугүй дайрахад бэлэн байгааг олж харав. Хэрэв одоо ингээд ухаан алдах юм бол дахиад хэзээ ч сэхэхгүй гэдгийг мэдэж байлаа. Жемийг зогсохтой зэрэг дэлт бүргэдүүд дайрна. Хажууд нь шувууны далавч сэр сэр хийх сонсогдсон боловч хөөх тэнхэлгүй болжээ. Хамаг тэнхээ нь нэгэнт барагджээ. Тэгээд нүүрээрээ халуун элс рүү шургалаа.

Том том махчин шувууд олз руугаа ухасхийлдэв.

-4-

Бямба гариг бол Кейптаунд зах гардаг өдөр. Гудамжаар нь худалдагч, худалдан авагч нар дүүрэн. Африкчууд, францууд, дүрэмт хувцастай цэргүүд, хуниас банзал, торон сүлжмэл цамц өмссөн англи хатагтай нар тус хотын Бреамеонстейн, Парк Таун, Бургерсдрон талбайд байдаг зах зээлээр бужигналдана. Энд хогшил тавилга, тэрэг, адуу мал, жимс ногоо, хувцас хунар, тоглоом, янз бүрийн орчуулгатай ном зэрэг зүсэн зүйлийн барааг худалдана. Кейптаун бямба гаригт есөн хэлийн хүн амьтан бужигнасан яармаг болж хувирдаг байлаа.

Банда цагаан арьстаны өөдөөс эгцэлж харахгүйг хичээн зах дээгүүр яаралгүй сажилж явлаа. Цагаан арьстаны өөдөөс эгцэлж харах аюултай. Хар, улаан, өнгөт арьстан гудамжаар пиг дүүрэн байх боловч засгийн эрх цөөнх цагаан арьстаны гарт байдаг. Банда тэднийг үзэн ядна. Энэ бол Бандагийн өөрийнх нь газар нутаг, цагаан арьстанууд бол энд outlanlanders. Өмнөд Африкт басуто, зулус, бечаун, матабеле гэх мэт олон овог аймаг бий. Эд нар бүгдээрээ банту ястанд багтана. Банту гэдэг үг “абанту” буюу ард түмэн гэсэн үгнээс гарчээ. Бандагийн өөрийнх нь баролон овог аймаг бол шилмэл дээд хэсэг нь. Урьд ӨмнөдАфрикт харт арьстны хүчирхэг гүрэн оршиж байсан гэж эмээгийнхээ ярьж өгсөнийг Банда дурсан санав. Өмнөд африк бол тэдний хаант улс, тэдний газар нутаг. Гэтэл одоо цагаан арьстанууд хамаг газрыг бага багаар эзлэн авч, хар арьстаныг эрх чөлөөгүй боол болгосон. Хар арьстан хүн одоо амьд мэнд тэсэж үлдэхийн тулд номхон дуугавартай байх ёстой. Гэвч энэ бол гадна өнгөн дээрээ юм. Жинхэнэ хэрэг дээрээ бол тэд эвлэршгүй тэмцэгчид хэвээрээ үлджээ.

Банда хэдэн настайгаа мэдэхгүй. Учир нь хар арьстанд төрсний гэрчилгээ өгдөггүй. Цаг үеийн дайн тулалдаан, их хүмүүсийн мэндэлсэн, таалал төгссөн өдөр, сүүлт од, газар хөдлөлт мэт болсон явдлаар хар арьстнууд насаа хэмжинэ.

Банда өөрийнгөө овог аймгийн тэргүүний хүү гэдгээ мэддэг. Өөрийн ард түмний төлөө тэмцэх ёстой гэдгээ ухаардаг. Банда банту овог аймгийнхны урьдыг хүчийг сэргэх ёстой. Иим эрхэм үүрэгтэйгээ ухамсарлаад нуруугаа цэхлэн алхаагаа хурдасгалаа. Тэгж яваад өөрийг нь нэг хүн харж байгааг мэдрэв.

Банда дан хар арьстан оршин суудаг хотын зүүн зах руу алгуурхан явлаа. Том том байшин, үнэт барааны дэлгүүр цөөрсөөр сүүлдээ дан биржгэр төмрөөр барьсан муусайн пин, ядуу урц овоохой дайралдах болов. Банда бохир муухай нарийн гудамжаар орж, араас нь дагаж яваа хүн байхгүйг баттай мэдэх гэж эргэн харлаа. Нэгэн муу модон байшингийн дэргэд хүрээд бас дахин эргэж тойрноо сайн харсны дараа хаалгыг хоёр тогшоод дотогшоо орлоо. Өрөөний буланд туранхай хар авгай хувцас оёод сууж байв. Банда тэр авгайд толгой дохиод хажуугийн өрөө рүү орлоо.

Тэнд орон дээр хэвтэж байгаа хүнийг Банда харлаа.

6 сарын өмнө Жеми Макгрегор анх ухаан ороод танихгүй айлын орон дээр хэвтэж байгаагаа мэджээ. Тэгээд болсон явдлыг нэхэн санав. Ээрэм цөлд хугархай хөлтэй хэвтэж байсан. Дэлт бүргэдүүд...

Унтлагын өрөөнд Бандаг орж ирэхэд “энэ одоо намайг ална” гэж Жеми боджээ. Жеми амьд байгааг Ван Дер Мерве ямар нэгэн янзаар мэдээд бүрмөсөн цааш харуулахаар хар зарцаа явуулсан шиг байна.

-Эзэн чинь өөрөө ирэхгүй яасан юм бэ? Хэмээн Жеми хоолойгоо хэржигнүүлэн өгүүлэхэд

-Надад эзэн байхгүй гэж Банда хэллээ.

-Вөн Дер Мерве яагаа вэ? Чамайг явуулсан юм биш үү?

-Үгүй. Миний энд байгааг тэр мэдвэл бид 2-г хоёуланг маань ална.

Нэг л хачин, утга учиргүй балай юм болж байна даа.

-Би хаана байна вэ? Би хаана байна хэлээд өгөөч?

-Кейптаунд

-Тийм байх ёсгүй. Би яаж нааш ирсэн юм бэ?

- Би чамайг нааш нь авчирсан.

Жеми Бандагийн нүдийг удтал ширтээд,

-Яах гэж?

-Чи надад хэрэгтэй. Өшөө авахад...

-Юун өшөө вэ? Гэсэнд Банда ойртож ирээд

-Бүх учир надад байгаа юм. Ван Дер Мерве охин дүүг минь хүчиндсэн. Дүү минь түүнд хүү төрүүлж өгөөд үхсэн. Миний дүү 11 настай байсан гэхэд нь Жеми

-Тэнгэр минь гэж дуу алдав.

-Би дүүгээ үхсэн өдрөөс хойш надад туслах цагаан арьстан хүнийг эрж явна. Тийм хүнийг би хуучин муу пинд, чамайг зодоход тусалж байхдаа олсон, Макгрегор оо. Чамайг цөлд аваачиж хаяахад үхчихсэн байсан гэж би нөгөөдүүлд хэлсэн юм. Дараа нь би буцаж очоод чамайг авсан. Ам мөлтөс амжиж очсон байна лээ.

Дэлт бүргэд хурц хошуугаа биед нь шигтгэж байсныг Жеми санаад хамаг бие нь дагжин чичрэв.

**Үргэлжлэл дараагийн дугаарт...**



